



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2016. 04. 24 № 470
таний -ны № -т

Г Нийцлийн талаарх дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцоо бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Монгол Ардын намын "Сонгуулийн мэрийн хөтөлбөр"-т Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянаж дүгнэлт гаргав.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох нам нь сонгуулийн мэрийн хөтөлбөрөө Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах хариуцлага хүлээнэ.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд намын боловсруулсан сонгуулийн мэрийн хөтөлбөр Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намаас ирүүлсэн "Сонгуулийн мэрийн хөтөлбөр"-ийг Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсөөллийн тухай хуульд нийцүүлэн дүгнэлт гаргав.

Дүгнэлт

Монгол Ардын намын Сонгуулийн мэрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны тогтооолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", 19 дүгээр тогтооолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцсэн болно.

Хувийг: Монгол Ардын намд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД

\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2016\0425NAG93.Docx

073787


000071



МОНГОЛ АРДЫН НАМ

“БИД ХАМТДАА ЧАДНА”

СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР-2016




000026

БИД ХАМТДАА

- ИРГЭДЭЭ ЯДУУРЛААС АВАРЧ
- ЭДИЙН ЗАСГАА ХЯМРАЛААС ГАРГАЖ
 - ЭХ ОРНОО ӨРНӨӨС САЛГАЖ
 - ТӨРИЙН ДАМПУУРЛЫГ ЗАСЧ
 - ТЭГШ ЖУРАМТ, БАЯН ХҮЧИРХЭГ
МОНГОЛОО ЦОГЦЛООЖ

ЧАДНА



Таны амьдралын үе шат бүрт зориулсан бодлогыг бид хэрэгжүүлнэ.

ТАНЫ ХҮҮХДЭД ЗОРИУЛЖ:


Бид таны хүүхдийг төрөхөд ч, цэцэрлэг, сургуульд ороход ч боловсрол, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ, сайн орчныг бүрдүүлнэ. Энэ нь эх орныхоо ирээдүйн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаа бидний үл хэрэг юм. Бид бүх хүүхдийг цэцэрлэгт хамруулна. “Хүүхдийн мөнгө”-ийг хүүхэд бүрт, “Үндэсний тэтгэлэг”-ийг нийт оюутнуудад ялгаваргүй олгоно. Олимпиин төрлийн спортуудыг Ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн хөтөлбөрт оруулна. Сурагчдыг нийтийн тээвэрээр төлбөргүй зорчуулдаг болгоно. Малчны хүүхэд 6-8 настайдаа сонголттойгоор сургуульд элсэх боломж олгоно. Оюутнууд сургалтын төлбөрөө төрөөс зээлж, ажилдаа орсны дараа буцаан төлдөг тоогтолцоог бүрдүүлнэ. Оюутан, залуусын цагийн ажил, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Оюутан, залуусыг ажиллуулсан, цалинтай дадлагажуулсан аж ахуйн нэгж, иргэнийг урамшуулдаг болно. Хүүхэд залуучууд маань дэлхийд өрсөлдөхүйц боловсролтой болж, амьдралаа тэтгэн дээшилүүлж, аав ээжээ ачилж, эх орныхоо хөгжлийн бааганаас өргөлцөх бодлогыг бид санал болгож байна.

ТАНЫ ГЭР БҮЛД ЗОРИУЛЖ:

Бид таны гэр бүлийг дэмжин тэтгэх, дэмнэн дэвжээх бодлогыг дэвшүүлсэн. Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын бүтэц бий болгоно. Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, гэр бүл салалт, хүчирхийллийг бууруулна. Төрх толгойлсон эцэг, эх, орлого багатай өрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ тусгайлан дэмжинэ. Хүн амын өсөлтийг дэмжиж, үр хүүхээ өсгөн бойжуулах орчин нөхцөлийг сайжруулан “Цалинтай ээж” хөтөлбөр хэрэгжүүлнэ. Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг цалингийн 75 хувиар биш, 100 хувиар тооцдог болгоно. Хүүхэд төрүүлэн өсгөх бүрт зэжүүдийн ажилласан жилийг 1,5 жилээр нэмэгдүүлэн тооцож, “Одонтой зэжүүд”-ийн тэтгэмжийг нэмэгдүүлнэ. Бид хүүхдүүдийг, олон хүүхэд төрүүлсэн зэжүүдийг, таны гэр бүлийг бүхий л бодлогоороо дэмжин хамгаалах болно.

ТАНЫГ АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ БАЙХАД ЗОРИУЛЖ:

Өрийн дарамтыг бууруулж, эдийн засгаа сэргээн босгоно. Хямралын үеийн хүү торгууль, зээлийн нөхцөлийг хөнгөвчлөх, хугацааг хойшилуулах, найдваргүй зээлдээгчийн жагсаалтаас хасч, төрөөс авч чадахгүй байгаа ажлын хөлсийг нь олгох зэрэг арга хэмжээг авна. Бизнес дэх төрийн оролцоо, дарамт, шахалтыг багасгана. Тусгай зөвхөөрлийн тоог 3 дахин цөөрүүлнэ. Арилжааны зээлийн хүг бууруулж, хугацааг уртасгана. НӨАТ-ыг оноочтой болгож, хөдөө орон нутагт бизнес эрхлэхийг дэмжинэ. Үйл ажиллагаагаа зогсоосон бизнес эрхлэгчдэд дахин урам зоригтой ажиллах боломж нээж өгнө. Аймаг бүрт үйлдвэр байгуулна. Шинээр аж ахуй эрхлэлтийг урамшуулдаг тоогтолцоог бүрдүүлнэ. Бид татвар нэмэхгүй. Шинэ төрлийн татвар бий болгохгүй. Эдийн засгийн хямралын өртгийг иргэдээр төлүүлэхгүй. Бага орлоготой аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь болгон бууруулах бодлого хэрэгжүүлнэ. Үндэсний томоохон бизнес эрхлэгчдээ дэмжинэ. Орлого багатай



иргэдээ ч тэтгэнэ. Монгол хүний үнэ цэнэ, бүтээмж, өрсөлдөх чадвар, үнэлэмжийг бүх салбарыг өсгөнө. Цалин, урамшууллыг өсгөж, өрхийн сарын дундаж орлогыг хоёр дахин нэмэгдүүлнэ.

Энэ бүх бодлогын үр дүнд таны амьдралд ч, эдийн засагт ч, улс оронд ч итгэл найдварын өөрчлөлт бий болох бодлогыг бид санал болгож байна.

ТАНЫГ АЯ ТУХТАЙ АМЬДРАХАД ЗОРИУЛЖ:

Нийслэл, аймгийн төвүүдийн хот байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үе шаттай хэрэгжүүлнэ. Улаанбаатар хотын дүүрэг бүрт цэцэрлэгт хүрээлэн, хиймэл нуур, усан байгууламжуудыг барина. Төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулахын тулд "Эко хот" хөтөлбөр хэрэгжүүлж, хийн түлшний хэрэглээг нэвтрүүлнэ. Автомашингүй гудамж байгуулна. Нийслэлийн баруун зүүн, өмнөд хойд бүсийг холбосон хурдны зам, мөн дугуйн зам шинээр барина. Улаанбаатар хотыг дүүрэг бүрээр нь төлөвлөлт хийн хөгжүүлнэ. Хашаандaa амины орон сууц барьсан айлыг ипотекийн зээлд хамруулна. Ард түмний мэдлийн төрийн өмчтэй том эмнэлгүүдийг хувьчлахгүй. Бүх эмнэлгийн үзлэгийн цаг, очер, дугаарыг гэрээсээ захиалдаг системтэй болгоно. Хуулийг хүн бүрт тэгш үйлчилдэг болгоно. Бидний бодлого таныг амар тайван, аюулгүй амьдрахад зориулагдсан.


АХМАД ҮЕИЙНХЭНДЭЭ ЗОРИУЛЖ:

Бид таныг улс орондоо хийсэн бүтээснээз үнэлүүлж, амар амгалан амьдрах орчныг илүү сайжруулна. Тэтгэврийн насыг нэмэгдүүлэхгүй, нийгмийн даатгалын шимтээлийг өсгөхгүй. Шударга халамжийн системийг тогтооно. Бид тэтгэвэр, тэтгэмжийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. Ахмадуудаа тэтгэврийн зээлийн өрөнд оруулж байгаа бодлогыг өөрчилж, тэтгэврийн зээлийн хүүг 10 хувь болгон бууруулна. Ахмадуудын мэдлэг, туршилагыг залуу үеийнхэнд өвлийлэх зорилгоор "ахмад зөвлөх" ажиллуулж, "Ач санах" хуулийг батлан хэрэгжүүлнэ. Хүн амынхаа дундаж наслалтыг нэмэгдүүлнэ. Ахмад настанд зориулсан эмнэлгийн үйлчилгээ, асаргаа, сувилгааг өргөжүүлнэ. Та сэтгэл амгалан амьдарч, үр ач, эх ороороо бахархаж, өндөр насандаа авах ёстой бүхий л хүндлэл, баталгаат байдлыг хүртэнэ.



АГУУЛГА

| | |
|---|-----------|
| НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО | 6 |
| 1.1. Эрүүл, аз жаргалтай – Эх, үрс | 6 |
| 1.2. Хүүхдэд ээлтэй – Сурах орчин..... | 7 |
| 1.3. Төлбөрийн дарамтгүй, төгсөөд ажилтай -Оюутан, залуучууд..... | 8 |
| 1.4. Ажилтай, орлоготой, бат бөх - Гэр бүл..... | 10 |
| 1.5. Төр түмнийхээ ивээлд байх ахмадууд, зорилтот бүлэг..... | 11 |
| 1.6. Хилийн чанад дахь - Монголчууд..... | 12 |
| 1.7. Иргэндээ ээлтэй - Эрүүл мэнд, спорт..... | 13 |
| 1.8. Соёл урлаг, шинжлэх ухаан, мэдээлэл технологи | 15 |
| ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | 16 |
| 2.1. Хямралыг даван туулах “Онцгой нэхцэл” арга хэмжээ | 16 |
| 2.2. Хариуцлагатай, ил тод, хэмнэлттэй төсөв | 17 |
| 2.3. Зохистой, хяналттай мөнгөний бодлого | 18 |
| 2.4. Уул уурхайн хөгжил | 18 |
| 2.5. Хөгжлийг тэтгэгч-Дэд бүтэц..... | 19 |
| 2.6. Импортлогч орноос-Экспортлогч орон | 20 |
| 2.7. Хувийн хэвшил- Ажлын байр | 22 |
| 2.8. Газар тариалан- Экологийн эрүүл хүнс | 23 |
| 2.9. Монгол малчин | 24 |
| ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО..... | 26 |
| 3.1. Хүний эрүүл мэнд, байгальд ээлтэй ногоон хөгжил | 26 |
| 3.2. Экосистем, унаган байгалийн тогтвортой байдал..... | 26 |
| 3.3. Байгаль хамгаалалд -бүх нийтийн оролцоо | 27 |
| 3.4. Аялал жуулчлал- Соёлын гүүр | 28 |
| ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | 29 |
| 4.1 Төлөвшсөн эрх зүйт төр- тогтвортой, хариуцлагатай засаглал..... | 29 |
| 4.2 Иргэндээ ойр- Төрийн үйлчилгээ | 30 |
| 4.3 Хараат бус, шударга хууль шүүхийн байгууллага | 31 |
| 4.4 Иргэн хүний эрх, эрх чөлөө | 32 |
| 4.5 Батлан хамгаалах бодлого | 33 |
| 4.6 Гадаад бодлого..... | 34 |
| ТАВ. НИЙСЛЭЛИЙН ХӨГЖИЛ | 35 |
| 5.1 Хот төлөвлөлт- дэд бүтэц..... | 35 |
| 5.2 Орон сууцжуулах таатай нэхцэл | 36 |
| 5.3 Эрүүл, цэвэр, аюулгүй орчин | 36 |
| 5.4. Үйлчилгээ нь шуурхай Улаанбаатар | 37 |



НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО

1.1. Эрүүл, аз жаргалтай – Эх, урс

Бодит байдал

Эдийн засгийн уналт иргэдийн аж амьдралд хүндээр тусч байна. Ажилгүйдэл, ядуурал газар авч, иргэдийн орлого огцом буурлаа. Эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухаан зэрэг салбарууд хямран доройтож иргэд төрийн үйлчилгээг авахад бэрхшээлтэй боллоо.

Улаанбаатар хотын төрөх эмнэлгүүд хүчин чадлаасаа 3 дахин их ачаалалтай ажиллаж байна. Энэ байдлыг сайжруулах чиглэлээр сүүлийн 3 жилд дорвийтой ажил хийгдсэнгүй, 2011 онд Яармагт эхэлсэн төрөхийн барилгын ажил дуусаагүй балгас болж үлдлээ.

Жилдээ дунджаар 80000 эх төрж байна. Сүүлийн жилүүдэд нярайн эндэгдэл өсөх хандлагатай болж байна. 2015 оны байдлаар 91700 эх гэртээ хүүхэд асарч байгаа статистик мэдээ гарчээ. Энэ үзүүлэлтээр 0-2 насны хүүхэдтэй 240000 эхээс 38 хувь нь буюу 3 эх тутмын нэг нь хүүхдээ асраад ажил эрхлээгүй, орлогогүй байна.

Монгол Улсын хэмжээнд 2015-2016 оны хичээлийн жилд нийт 1288 хүүхдийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс төрийн өмчийн 826 цэцэрлэг, хувийн 462 цэцэрлэг байна. 2015 оны байдлаар 225 мянган хүүхэд цэцэрлэгт хамраадж, харин 36 мянган хүүхэд цэцэрлэгээс гадуур гэртээ хүмүүжж байна.

Бид ингэж шийднэ

- 1.1.1. Ургийн эрт үеийн оношилгоонд жирэмсэн эхчүүдийг бүрэн хамруулж, эх нялхсын эндэгдлийг бууруулна.
- 1.1.2. Хүүхдийг эхийн хэвлийд бойжих үеэс нь үндэсний өв уламжлал, урлаг соёлоор дамжуулан зөрэгээр нөлөөлөх чадавхийг эцэг, эхчүүдэд бий болгох бодлого хэрэгжүүлнэ.
- 1.1.3. 5 хүртэлх наслын хүүхдийн эмийн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 1.1.4. Төрөх эмнэлгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 1.1.5. Хүүхдийн эмнэлгүүдийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжийг сайжруулахад эхний ээлжинд анхаарна.
- 1.1.6. Улаанбурхан, салхин цэцэг гэх мэт халдварт өвчний дархлаажуулалтыг бүрэн шийдэж, өвчлөлийг эрс бууруулна.
- 1.1.7. Бага наслын хүүхдийг осол, гэмтлээс сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэн, осол, эндэгдлийн түвшинг 2 дахин бууруулна.
- 1.1.8. Хүүхэд төрүүлсэн ээжүүдэд даатгуулсан хэлбэрээс нь үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон тэтгэмж олгох эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 1.1.9. Хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа эхчүүдийн НДШ төлсөн хугацаа тасрахгүй байх боломж бүрдүүлнэ.



- 1.1.10. Төрүүлж, өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан хугацааг 1,5 жилээр нэмэгдүүлэн тооцно.
- 1.1.11. Хүүхдийн мөнгийг хүүхэд бүрт ялгаваргүй олгоно.
- 1.1.12. Хүүхдийг хувийн даатгалд хамруулж, боловсрол эзэмших, эмнэлгийн тусlamж авах, тэжээгчээ алдсан үед тэтгэмж авах санхүүгийн нэмэлт баталгааг бурдүүлнэ.
- 1.1.13. Хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг чухалчлан үзэж, “хүүхдийн хөгжлийн ордон”, “хүүхэд хамгаалах” төвүүдийг дэмжинэ. Хараа хяналтгүй хүүхдийн бүртгэл, хяналтыг сайжруулж, насанд хүртэл нь хамгаалах, амьдралд хөлөө олоход нь туслах бодлого хэрэгжүүлнэ.
- 1.1.14. З хүртэл насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/ болон орлого багатай өрхүүдийг төрөөс дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 1.1.15. “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөр хэрэгжүүлж, цэцэрлэгийн чанар, хүртээмж, материаллаг баазыг нэмэгдүүлнэ.
- 1.1.16. Ажилчдынхаа хүүхдүүдэд зориулсан “Байгууллагын цэцэрлэг”-ийг татварын бодлогоор дэмжинэ.
- 1.1.17. З ба түүнээс дээш хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах, одонтой ээжүүдийн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар “Цалинтай ээж” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.2. Хүүхдэд ээлтэй – Сурах орчин

Бодит байдал


Сургуулийн насын буюу 6-17 насын нийт 573,365 хүүхдээс ЕБС-д 505,816 хүүхэд, МСҮТ-д 42,618 хүүхэд сурч байна. Сургуульд ороогүй 6 настнууд, суурь боловсрол буюу 9 дүгээр анги төгсөөд хөдөлмөрийн зах зээлд шилжсэн хүүхэд, сургууль завсардсан зэрэг нийт 24,931 хүүхэд сургуульд хамрагдаагүй байна.

Монгол Улсын хэмжээнд 2015-2016 оны хичээлийн жилд нийт 762 ЕБС үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс төрийн өмчийн 628 сургууль, хувийн өмчийн 134 сургууль байна. Нийт 37 МСҮТ үйл ажиллагаа явуулж байна.

ЕБС-ийн анги дүүргэлт хотод дунджаар 30 хүүхэд, хөдөө орон нутагт 25,8 хүүхэд байгаа боловч нийслэл хот, аймгийн төвд 2 дахин өндөр анги дүүргэлттэй, 2-3 ээлжтэй сургууль цөөнгүй байна. 2014-2015 оны хичээлийн жилийн байдлаар улсын хэмжээнд 22 сургууль 3 ээлжээр хичээллэж байгаагаас 21 нь Улаанбаатар хотод байна. Байдал ийм байхад “Чингис”, “Самурай” бондын мөнгөнөөс сургууль барихад нэг ч төгрөг зарцуулсангүй.

Бид ингэж шийднэ

- 1.2.1. Сурагчдад эх орноо хайрлах, хүрээлэн буй орчноо хамгаалах мэдлэг, хүмүүжил олгоно.
- 1.2.2. Сургуулийг хүүхдэд аюулгүй, эрүүл суралцах орчин болж, гэрэлтүүлэг,



- гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгоно.
- 1.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна.
- 1.2.4. Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгүүдийн ачааллыг бууруулж, нэг анgid 30-аас ихгүй хүүхэд суралцдаг болгох бөгөөд З ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулиудыг 2 ээлжтэй болгоно.
- 1.2.5. Малчны хүүхдийг 6-8 насны сонголттойгоор сургуульд элсэн суралцах боломж бүрдүүлнэ.
- 1.2.6. Багшийн хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, ажиллах нөхцөлийг сайжруулан ур чадвар, ажилласан жил, сурагчдын амжилтаас нь хамаардаг цалин, хөлс, урамшууллын шинэ систем бий болгоно.
- 1.2.7. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гэр, сургуулийнхаа хооронд нийтийн тээврээр зорчих боломж бүрдүүлнэ.
- 1.2.8. Боловсролын салбарын удирдах ажилтан, багш сурган хүмүүжүүлэгчдийг чадваржуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулна.
- 1.2.9. Сургалтын стандарт, хөтөлбөр, сурах бичгийн агуулга, чанарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны түүх, соёл, өв уламжлалд тулгуурлан шинэчилнэ.
- 1.2.10. Хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөр боловсруулж, сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.
- 1.2.11. Сурагчид дотуур байрандаа аюулгүй, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг сайжруулж, сургуулиас үзүүлж буй үйлчилгээний нэгдсэн стандартыг бий болгоно.
- 1.2.12. Сурагчдад сонирхол, авьяас чадвараа харгалзан мэргэжлээ зөв сонгоход нь туслах, мэргэжлийн чиг баримжаа олгож, хичээлийг сургалтын хөтөлбөрт тусгаж, энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлж буй иргэн, төрийн бус байгууллагыг бодлогоор дэмжинэ.

1.3. Төлбөрийн дарамтгүй, төгсөөд ажилтай -Оюутан, залуучууд

Бодит байдал

2014 оны байдлаар 18-24 насны 379,100 залуусаас 162,626 нь их, дээд сургуульд суралцаж, 102,300 нь ажил эрхэлж байгаа бол 114,174 нь сургуульгүй, ажил эрхлээгүй залуучууд байна.

Монгол Улсын хэмжээнд 2015-2016 оны хичээлийн жилд нийт 100 Их дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс төрийн өмчийн 17 дээд сургууль, хувийн өмчийн 78 сургууль байна.

Их, дээд сургуулиудын сургалтын төлбөр 2012 оноос хойш 50 орчим хувцар ёсч, өрхөөс гарах боловсролын зардлыг 28 хувиар нэмэгдүүлсэн нь эцэг эхчүүдээд болон боловсрол эзэмших хүсэлтэй залуучуудад санхүүгийн томоохон дарамт учруулах боллоо. Боловсролын



салбарт мэргэжилтэн бэлтгэх бодлого доголдож, мэргэжлийн боловсон хучний эрэлт, нийлуулэлтийн харьцаа алдагдлаа. Манайд өнөөдөр ажилгүй иргэдийн 30 орчим хувь нь дээд боловсролтой иргэд байна.

Оюутнууд ажил хийж орлого олохыг хүсдэг ч хариуцсан яам, байгууллага нь тэдний хүсэлт эрмэлзэл дээр тоглож “сумын залуус”, “гавшгай залуус” зэрэг суржин нэртэй, өвөөж баатай цөөн тооны төслөөс хэтэрсэнгүй. Ажил эрхлээгүй иргэдийн 70 гаруй хувь нь 18-35 насны залуучууд байна.

Бид ингэж шийднэ

- 1.3.1. Төрийн өмчит их, дээд сургуулиудыг хувьчлахгүй бөгөөд удирдах зөвлөлийг улс төрийн нөлөөллөөс ангид байлгаж, сургалтын орчин, чанарыг дээшлүүлнэ.
- 1.3.2. Их, дээд сургуулиудын эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд Төрөөс зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлнэ.
- 1.3.3. “Боловсролын зээлийн сан” шинээр байгуулж оюутан, залуус сургалтын төлбөрөө зээлээр төлж, сургуулиа төгссөний дараа ажил эрхлэх явцдаа эргүүлэн төлөх боломж бүрдүүлнэ.
- 1.3.4. Өрхийн 3 ба түүнээс дээш хүүхэд нь их, дээд сургуульд зэрэг суралцаж байгаа бол санхүүгийн дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 1.3.5. Үндэсний тэтгэлэг 70200 төгрөгийг үргэлжүүлэн олгож, сурлагын амжилтыг шударгаар үнэлэх журам бий болгоно.
- 1.3.6. Оюутны дотуур байрны хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлнэ.
- 1.3.7. Оюутнууд харьялал харгалзахгүйгээр эмнэлгийн үйлчилгээ авдаг болно.
- 1.3.8. Аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд оюутныг цагаар ажиллх боломж нэмэгдүүлж, аж ахуй нэгжийг урамшуулах замаар “Орлоготой оюутан” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.9. Мэргэжлийн боловсрол сургалтын төвд суралцагчдын оролцоонд тулгуурлан хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах бодлогыг дэмжинэ.
- 1.3.10. Сургууль төгссөн залуучуудыг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлого баримтална.
- 1.3.11. Монгол залуусаа сургаж дадлагажуулан ажлын байраар хангасан бодлого барьж, гадаадаас авдаг ажиллагсдын тоог 50-иас дээш хувиар бууруулна.
- 1.3.12. “Мэргэжилтэй ажилтан” бодлогын хүрээнд жилд 20,000-аас доошгүй залуучуудыг мэргэжил, ур чадвар эзэмшиүүлэх сургалтад хамруулна.
- 1.3.13. Өндөр хөгжилтэй орнуудын их, дээд сургуулиудад бакалавр, магистр, докторын сургалтанд элсэгчдийг ил тод нээлттэй сонгон шалгаруулж, суралцагсдын тоог 2 дахин нэмэгдүүлнэ.
- 1.3.14. Өндөр технологийн 2000 энтрепренёр мэргэжилтэн бэлтгэнэ.



- 1.3.15. Залуучуудад бизнесийн гарааны дэмжлэг үзүүлж, их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгсөгчдийг тоног төхөөрөмжийн лизинг, жижиг зээлд хамруулах арга хэмжээ авна.

1.4. Ажилтай, орлоготой, бат бөх - Гэр бүл

Бодит байдал

Эдийн засгийн хямрап гүнзгийрч, ажилгүйдэл ядууралт газар аеч, нийгмийн бухимдал эрс нэмэгдлээ. Энэ нь гэр бүлийн амьжиргаанд хундрэл учруулж хүчирхийлэл, салалт зэрэг сөрөг үзэгдлийг эрс нэмэгдүүлэх боллоо. Зөвхөн 2015 онд 3522 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх оноос 30 хувиар нэмэгдэж, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрээ 26 хувиар өсчээ.

Гэр бүлийн салалт, таагүй байдлын улмаас олон мянган хүүхэд багачууд өнчирч, эцэг эхийн хайр халамж, хараа хяналт дутагдаж, хүчирхийлэл, хүнд хучир хөдөлмөр, мөлжлэгт өртөх нь эрс нэмэгдэж байна. 2014 оны байдааар Монгол Улсад нийт 823,412 өрх байгааагийн 103,192 нь өрх толгойлсон эх /эцэг/, тэдний 80-90 хувь нь бага орлоготой өрх байна.

Бид ингэж шийднэ

- 1.4.1. Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах эрх зүйн таатай орчин бүрдүүлнэ.
- 1.4.2. Хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах чадвартай болгон төлөвшүүлэх цогц бодлого хэрэгжүүлнэ.
- 1.4.3. Гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлж, хүүхэд төрсэн цагаасаа эхлэн өмчийн эзэн байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 1.4.4. Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн Төрийн байгууллагын бүтэц бий болгоно.
- 1.4.5. Хувийн хэвшлээ бүх талаар дэмжих, ЖДҮ, өрхийн болон бичил зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хөнгөн үйлдвэрийн салбарыг сэргээн хөгжүүлэх-“21:100”, “Монгол мал”, “Атрын аян” зэрэг томоохон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг тууштай дэмжинэ.
- 1.4.6. Монгол хүний үнэ цэнэ, үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлогыг бүх салбарт баримтална.
- 1.4.7. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг үе шаттай нэмэгдүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар өрхийн дундаж орлогыг өсгөх бодлого баримтална.
- 1.4.8. Ипотекийн зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлж, зээлийн нөхцлийг сайжруулах бодлого баримтална.



- 1.4.9. Залуу гэр бүл, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш олон хүүхэдтэй гэр бүлийг тэргүүн ээлжинд орон сууцжуулах, орон сууцны түрээсээ урьдчилгаанд шилжүүлэн тооцуулдаг гадны орны туршлагаас нэвтрүүлэх бодлого баримтална.
- 1.4.10. Өрхийн орлого, зарлага, ядуурлын түвшинг тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг сайжруулж, бодит амьдралд нийцүүлнэ.
- 1.4.11. Орлогын албан татварыг орлогын түвшингээс хамаарсан шатлалтай болгон, “баян, ядуугийн” ялгааг бууруулж, нийгмийн бүтцэд зонхилох чинээлэг дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.
- 1.4.12. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 1.4.13. Өрх толгойлсон болон бага орлоготой өрхийн гишүүдэд үзүүлэх дэмжлэг, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 1.4.14. Өрх толгойлсон эх /эцэг/-ийн нийгмийн хамгааллын хуулийг батлан хэрэгжүүлнэ.

1.5. Төр түмнийхээ ивээлд байх ахмадууд, зорилтот бүлэг


Бодит байдал

2015 оны байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэврийг нийт 355,1 мянган ирээн авч байгаагийн 254,9 мянга нь өндөр насны тэтгэвэр авагчид байна

Нийт тэтгэвэр авагчдын 60 хувь нь тэтгэврийн доод хэмжээ буюу 195,000-230,000 төгрөгийн тэтгэвртэй, дундаж тэтгэврийн хэмжээ 280,000 орчим төгрөг, тэтгэвэр авагч ахмадуудын 86 хувь нь тэтгэврийн зээлтэй байна. Сүүлийн 3 жилд ахмадуудын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх дорвигтой арга хэмжээ аваагүйгээс тэдний ихэнх нь тарчиг амьдрах боллоо. Харж хандах үр хүүхэдгүй ганц бие ахмадуудын байдал улам хүнд болж байна.

Бид ингэж шийднэ

- 1.5.1 “Төрөөс ахмадын талаар баримтлах бодлого” гаргаж, “Ач санах” хуулийг батлан хэрэгжүүлнэ.
- 1.5.2 “Ахмадын зөвлөх үйлчилгээ”-г бий болгож, хүүхэд, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадварыг өвлүүлнэ.
- 1.5.3 Азай буурлууддаа “Насны хишиг” тэтгэвэр олгох эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 1.5.4 Тэтгэврийн зээлийн хүүг бууруулах бодлого баримтална.
- 1.5.5 Нийгмийн даатгалын салбарт хувийн хэвшлийн оролцоог хангах замаар иргэд нийгмийн баталгаагаа нэмэгдүүлэх боломж бүрдүүлнэ.



- 1.5.6 Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг жил бүр нэмэгдүүлэх, тэтгэврийн зөрүүг арилгах бодлого баримтална.
- 1.5.7 Ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг өргөжүүлж, асрамжийн газар байгуулахыг дэмжинэ.
- 1.5.8 Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 1.5.9 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална.
- 1.5.10 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурх, хөгжих үйлчилгээ үзүүлдэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.

1.6. Хилийн чанад дахь - Монголчууд

Бодит байдал

Гадаадад суугаа 125,0 мянган Монголчуудын 33,0 мянга нь албан ёсны зөвшөөрөлтэй ажил, хөдөлмөр эрхэлж, 29,0 мянга нь суралцаж байна. Харин хууль бусаар гадаад улсад оршин сууж байгаа иргэдийн тоо 39,0 мянга давжээ. Мөн гадаад цргэнтэй гэр бүл болсон 6,3 мянган цргэн байдал. Дэлхийн 58 улс, орнуудад амьдарч, ажиллаж, сурч байгаа иргэдийн тоог авч үзвэл БНСУ-д 25,8 мянга, АНУ-д 25 мянга, БНКазУлсад 15,0, БНХАУ-д 9,8 мянга, Япон улсад 5,7 мянган цргэн тус тус ногдох байгаа нь эдгээр орнуудад манай иргэд илүү төвлөрч байгааг харуулж байна.

Бид ингэж шийднэ

- 1.6.1. Хилийн чанадад ажиллаж, амьдарч, сурч буй иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалж, эрх ашиг нь зөрчигдсөн нөхцөлд хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.
- 1.6.2. “Зөгийн үүр” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, гадаадад сурч, ажиллаж өндөр мэдлэг, боловсрол, технологи, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо тогтвортой суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.6.3. Нарийн мэргэжлээр сурч, хилийн чанадад өндөр мэргэжлийн, академик ажил эрхэлж байгаа оюунлаг Монголчуудад эх орныхоо хөгжилд алсаас хувь нэмэр оруулах боломж бүрдүүлж, Монгол улс дахь эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, лабораторитой холбож өгнө.
- 1.6.4. Монгол соёл, өв уламжлал, эх хэлээрээ суралцах боломж бүрдүүлж, хилийн чанадад байгуулагдсан “Монгол сургууль, цэцэрлэг”-ийн үйл ажиллагааг сурх бичиг, сургалтын арга зүйгээр дэмжинэ.
- 1.6.5. Гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийнхээ эрх ашгийг түүштэй хамгаалж, гадаадад байгаа “Монгол иргэддээ туслах сан”-г өргөтгэж, иргэддээ бодитой тусламж, дэмжлэг үзүүлдэг болно.



1.7. Иргэндээ ээлтэй - Эрүүл мэнд, спорт

Бодит байдал

Эрүүл мэндийн салбар зээнгүйдэж, иргэдийн эрүүл явах, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах баталгаа үгүй боллоо. Нийслэлийн эмнэлгүүд ачааллаа даахаа больж, иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрх хязгаарлагдаж, хөсөр хаягдаж байна.

Сумдын эмнэлгүүд иргэдэд шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх боловсон хүчин, материаллаг нөөцөөр дуттмаг байгаагаас хөдөөгийнхөн аймгийн төв, нийслэл хотруу хошуурсан урсгал бий болж нийслэлийн эмнэлгүүдийн ачааллыг улам нэмэгдүүлж байна. Үүний улмаас аймгийн төв, хот орж эмнэлэгт үзүүлэх гэсэн иргэн дунджаар 500,000-1,000,000 төгрөгийн зардал гаргаж, олон хоног дугаар хулээж байна.

Эмнэлгүүд ачааллаа ийнхүү дийлэхгүй байхад эмнэлгийн барилгын зориулалтыг өөрчлөх, шинэ төрөх эмнэлэг барих ажлыг зогсоох зэрэг ноцтой алдааг гаргаж эрүүл мэндийн салбарын хөгжлийг сааруулж байна. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжгүй, чанаргүй байдал нь хөрөнгө гадагшлах урсгалыг нэмэгдүүлж, иргэдийн амьжиргаанд дарамт учруулах боллоо. Тухайлбал, иргэд гадаадад эмчлүүлэхэд жилд дунджаар 200 гаруй сая ам.доллар зарцуулсан байна.

Бид ингэж шийднэ

- 1.7.1. Эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоог бүрдүүлж, иргэдэд хүрэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 1.7.2. Эрүүл мэндийн салбарыг улс төрөөс ангид байлгаж, иргэд ар өврийн хаалгагүй, санхүүгийн дарамтгүй, эрүүл мэндийн чанартай хүртээмжтэй үйлчилгээг авч чаддаг болгоно.
- 1.7.3. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг 2 дахин нэмэгдүүлнэ.
- 1.7.4. ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт эрүүл мэндийн хичээл оруулна.
- 1.7.5. Нотолгоонд суурилсан бодлого тодорхойлохын тулд цаашид өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг ашиглан, эрүүл мэндийн үндэсний тооцоог тогтмол тооцоолдог чадавхийг бүрдүүлнэ.
- 1.7.6. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний салбарт төр хувийн хэвшлийн түншлэлд суурилсан хамтын ажиллагааг өрнүүлж, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, хэлбэрийг олшуулан гадаадад эмчлүүлэх, дотооддоо өндөр үнэтэй эмчилгээ хийлгэх зэрэг тохиолдлуудыг даатгалд хамруулдаг болно.
- 1.7.7. Эрүүл мэндийн үйлчилгээ авах шат дамжлага, чирэгдлийг эрс бууруулж, өвчтөний түүхийг цахимжуулан, эмнэлгүүдийн мэдээлэл технологийн программ хангамжийг сайжруулна.
- 1.7.8. Төр, хувийн хэвшлийн магадлан итгэмжлэгдсэн бүх эмнэлэг, лабораториуд шинжилгээний хариу, рентген зураг, томографи зэргийг харилцан хүлээн зөвшөөрдөг болгоно.



- 1.7.9. Эмнэлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс дуусаагүй барилгуудыг яаралтай ашиглалтанд оруулна.
- 1.7.10. Олон улсын жишигт нийцсэн эмчилгээ, үйлчилгээний төв байгуулах, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг төрөөс бодлогоор дэмжиж, хүнд өвчнийг дотооддоо эмчилнэ.
- 1.7.11. Иргэн хувийн эмнэлгээр үйлчлүүлэхэд ЭМД-аас хөнгөлөх хэмжээг нэмэгдүүлж, иргэнд учрах төлбөрийн дарамтыг бууруулна.
- 1.7.12. Иргэн бүрийг жилд 1 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах бодлого баримтална.
- 1.7.13. Өндөр үнэ, өртөгтэй компьютер томограф, МРАЙ зэрэг оношилгоо, зарим мэс заслын төлбөр зардлыг ЭМД-ын сангаас санхүүжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 1.7.14. Элэгний хорт хавдар, хатуурлын нас барагтыг эрс бууруулах, элэгний С вирусийн голомтыг 2020 он гэхэд устгаж, халдвартын тархалтыг таслан зогсоох “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.7.15. Нийгмийн халдварт өвчин ялангуяа сурьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх зардлыг нэмэгдүүлэн, иргэдийг уг өвчинд өртүүлэхгүй байх цогц арга хэмжээг авна.
- 1.7.16. Хөдөөгийн алслагдсан сумдад амьдарч байгаа малчид, иргэдийг үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулах явуулын эрүүл мэндийн үйлчилгээг хөгжүүлнэ.
- 1.7.17. Хөдөөгийн суманд ажиллахаар очсон эмч, мэргэжилтнүүдийг тогтвортой суурьшилтай ажиллуулах үүднээс хөнгөлөлттэй нөхцөлтэй байр орон сууцаар дэмжинэ.
- 1.7.18. Эмч, эмнэлгийн ажилтнуудыг мэргэжил, боловсролоо тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх, ажлын дэмжлэгт орчныг сайжруулах “Эмч хүн жаргалын эзж” нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.7.19. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадвар, нарийн мэргэшил, ажилласан жил, байгуулсан гавьяа зүтгэлээс хамаарсан цалин, хөлс, урамшууллын шинэ тогтолцоо нэвтрүүлнэ.
- 1.7.20. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын ажлын ачааллыг тооцож, норм, нормативтай болгон, илүү цагийн хөлсийг тухай бүрт нь тооцож олгодог болно.
- 1.7.21. Аймаг, дүүрэг бүрээс 20 эмч мэргэжилтэн, сувилагчийг өндөр хөгжилтэй улс оронд сурган, дадлагашуулахын зэрэгцээ гадны нарийн мэргэжлийн эмч мэргэжилтнийг урьж ирүүлэн, туршлага судална.
- 1.7.22. Нийтийн биеийн тамир, иог, бясалгал, зохистой хөдөлгөөн /фитнес/-ээр хичээллэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг ЭМД-ын сангаас урамшуулна.
- 1.7.23. “Их спортыг дэмжих сан” байгуулж, их спортыг төрийн ивээлд байлгана.
- 1.7.24. Багийн болон оюуны спортыг дэмжин, өвлийн спортын ордон байгуулна.



1.8. Соёл урлаг, шинжлэх ухаан, мэдээлэл технологи

Бодит байдал

Сүүлийн жилдүүдэд шинжлэх ухааны байгууллагуудын төсөөв байнга танагдаж, судлаачид, эрдэмтэд нь цалин, хангамж муутай, туршилт, судалгааны ажлын зардалгүй шахам явж ирлээ. Энэ нь шинжлэх ухааны салбарт төрийн цэгцтэй бодлого дутагдаж байгааг харуулж байна. Соёл урлагийн салбарт ч байдал адил байна. Энэ салбарын санхүүжилт, материаллаг бааз, удирдлагын чадавхи муудсан нь уран бүтээлийн чанарт сөргөөр нөлөөлөх боллоо.

Бид ингэж шийднэ

- 1.8.1. Монгол Улсад Ази, Европыг холбосон мэдээлэл дамжуулах өндөр хурдны сүлжээ бүхий өгөгдлийн төв (Data center) Монгол Улсад байгуулах боломж бүрдүүлж, Төрийн хамгаалалтанд авч, мэдээллийн аюулгүй байдлыг ханган олон улсын компаниуд чөлөөтэй транзит ашиглах боломж бүрдүүлнэ.
- 1.8.2. Шинжлэх ухаан, технологийн судалгаа, инноваци, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг 5 дахин нэмэгдүүлнэ.
- 1.8.3. Инноваци, гарааны бизнесийг хөгжүүлэх экосистем бүрдүүлж, оюуны үйлдвэрлэлийг дэмжиж, экспортыг нэмэгдүүлнэ.
- 1.8.4. Мэдлэгт суурилсан инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг тууштай баримталж, бус нутгийн хэмжээнд өрсөлдөхүйц инновацийн цогцолборыг хөгжүүлнэ.
- 1.8.5. Шинжлэх ухааны салбар, эрдэмтэд, хүрээлэнгүүдтэй хамтран шинэ технологи нэвтрүүлсэн хувийн аж ахуйн нэгжүүдийг урамшуулах бодлого хэрэгжүүлнэ.
- 1.8.6. Үндэсний соёл, урлагийг шинэ шатанд гаргах зорилгоор “Үндэсний байгалийн музей, театр, урлагийн цогцолборууд”-ыг байгуулж, соёлын үнэт зүйлс, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.
- 1.8.7. Үндэсний бахархал, оюуны дархлаа болсон соёл, урлагийн салбарыг төрийн ивээлд байлгаж, сонгодог урлагийн хөгжлийг бүхий л талаар дэмжинэ.
- 1.8.8. Оюуны өмчийн үнэлэмжийг нэмэгдүүлж, монгол хүний эзэмшиж буй зохиогчийн эрх, патентыг олон улсын түвшинд хамгаалах, сурталчлах чиглэлээр идэвхжүүлнэ.
- 1.8.9. Монголын үндэсний соёл, урлагийг гадаад өртөнцөд сурталчлан таниулахыг төрийн бодлогоор дэмжинэ.
- 1.8.10. “Монгол контент” бүтээгчдийг дэмжих бодлого баримтална.
- 1.8.11. Соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалт, музейн орчныг олон улсын жишигт хургэнэ.
- 1.8.12. Соёл, шинжлэх ухааны салбарын үнэлэмжийг дээшлүүлнэ.



ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Хямралыг даван туулах “Онцгой нөхцөл” арга хэмжээ

Бодит байдал

Эрх баригчдын алдаатай бодлогын уршигаар 2011 онд 17,3 хувьтай ёсч байсан эдийн засаг сүүлийн 4 жилд тасралтгүй унаж, 2016 онд ердөө 0.1 хувьд хүрэх урьдчилсан таамаг гарч байна. Монгол улс ӨРИЙН ГҮН АНГАЛ руу орлоо. Төсвийн алдагдал, өрийн дарамт нэмэгдэж, 2016 онд 2,6 их наяд төгрөгийг гадаад, дотоод зээлийн хүү, үндсэн төлбөрт төлөхөөр байна. Үүнээс зөвхөн зээлийн хүү 947,5 тэрбум төгрөг төсвөөс төлөхөөр байгаа нь 2011 оноос 25 дахин их үзүүлэлт юм.

Зээлийн хүүнд өгч буй энэ их мөнгө бол төрийн албан хаагчдын цалинг 400 гаруй мянган төгрөгөөр нэмэх, эсвэл мянган цэцэрлэг барих хөрөнгө байлаа.

БОДЛОГОГҮЙ, ХЯНАЛТГҮЙ, ӨР НЭМСЭН төсөөтэй боллоо. Монгол Улс 5 төсөөтэй болж, татвар төлөгчдийн мөнгийг хууль бусаар, хяналтгүй зарцуулж, улс орноо өрөнд орууллаа. Иймээс, бид бодлогын алдааг залруулж, иргэд, аж ахуйн нэгж, улс орноо өрийн дарамтаас гаргах, хямралыг даван туулах, эдийн засгаа “ДАХИН СЭРГЭЭХ” бодлогыг авч хэрэгжүүлнэ.

Бид ингэж шийднэ

- 2.1.1. Эдийн засгийн хямралыг даван туулах “Мэргэжлийн Засгийн газар” байгуулж, богино хугацаанд эдийн засгийг тогтвортжуулах хөтөлбөр боловсруулан ажиллана.
- 2.1.2. “Мэргэжлийн Засгийн газар” нь мэргэжлийн өндөр ур чадвартай байж, өнгөрсөн хугацаанд гаргасан бодлогын алдааг засах, ард иргэд, аж ахуйн нэгж, улс орноо өрийн дарамтаас гаргах, ард иргэдийнхээ тогтвортой амьжиргаа, орлогыг нэмэгдүүлэх бүхий л арга замыг эрэлхийлэн, эрчимтэй, шуурхай арга хэмжээ авч ажиллана.
- 2.1.3. “Мэргэжлийн Засгийн газар” нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангасан, хөрөнгө оруулалт, бүтээмжийг нэмэгдүүлсэн, бизнес эрхлэлт, баялгийн зохистой хуваарилалтыг дэмжсэн хариуцлагатай, өндөр сахилга баттай төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.1.4. Засгийн газар өр зээлийн нөхцөл, гэрээний асуудлаар дахин хэлцэл хийх, үндсэн төлбөрийн төлөх хугацааг хойшлуулах, улсын төсөөт тулгарч буй өрийн дарамтыг үе шаттайгаар бууруулах арга хэмжээ авна.
- 2.1.5. Эдийн застийн хямралаас богино хугацаанд гарах, банк санхүүгийн салбарын хүндрэлийг даван туулах, эмзэг байдлыг бууруулах, эрдлийг багасгахад олон улсын болон бус нутгийн банк санхүүгийн байгууллагуудтай нягт хамтран ажиллана.



2.2. Хариуцлагатай, ил тод, хэмнэлттэй төсөв

Бодит байдал

Улсын нэгдсэн төсвийн орлого сүүлийн 3 жил дараалан 1 их наяд гаруй төгрөгөөр тасарсан. Гэтэл жил бүр төсвийн зарлагыг 15 хүртэлх хувцар нэмэгдүүлсэн ба төсвийн алдагдал 1 их наяд төгрөг давах нь хэвийн үзэгдэл боллоо. Шинээр их хэмжээний өр зээл тавьсан ч, зарлага санхүүжилт нь хяналтгүй болсноос гадна, төрийн ажил үйлчилгээ гүйцэтгэсэн олон мянган иргэд, аж ахуйн нэгжид санхүүжилтийг цаг тухайд нь олгохгүй хохироож байна.

Төрийн албан хаагчдын тоо 30 гаруй мянгаар, ялангуяа тусгай хангамж бүхий дарга нарын тоо эрс нэмэгдлээ. Тусгай хангамж эдлэх эрхэгүй 220 гаруй албан тушаалтан албаны унаа хэрэглэж байгааг Үндэсний аудитын газраас хийсэн шалгалтаар тогтоосон. Зөвхөн Нийслэлийн Засаг дарга гэхэд 6 орлогчтой боллоо. Энэ нь татвар төлөгчдийн мөнгийг үр ашиггүй зарцуулж, төсвийн ачааллыг нэмэгдүүлсний ипрэл юм.

Бид ингэж шийднэ

- 2.2.1. Төсвийн үр ашиггүй зардлыг танаж, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна.
- 2.2.2. Төр төсвийн алдагдлаа санхүүжүүлэхийн тулд өндөр хүүтэй зээл, эх үүсвэр ашиглахаас татгалзана. Төр арилжааны банкнаас авах зээлийг бууруулах замаар иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийг нэмэгдүүлнэ.
- 2.2.3. Төсвийн нэгдмэл байдлыг ханган, төсвийн гадуурх санхүүжилтийг зогсоож, хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгоно.
- 2.2.4. Төсвийн хөрөнгө оруулалтаар гагцхүү нэн шаардлагатай объектуудыг санхүүжүүлнэ.
- 2.2.5. Монголбанкны хэрэгжүүлсэн “Үнэ тогтвортжуулах” хөтөлбөр, Хөгжлийн банкны Чингис, Самурай бонд, зээлийн зарцуулалтыг дүгнэж, төсөл хөтөлбөрт үнэлгээ хийж, зориулалт бусаар ашигласан, хугацаа хэтэрсэн зээлийг буцаан төлүүлнэ.
- 2.2.6. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг үр дүнтэй, ард иргэдэд нээлттэй ил тод болгоно.
- 2.2.7. Төрийн байгууллагуудын ажил үүргийн давхардлыг арилгах, нэгтгэх замаар төсвийн байгууллагуудын тоог цөөлж, оновчтой бүтцийг бий болгоно.
- 2.2.8. Иргэд, Аж ахуйн нэгжүүдийн орлого, бизнесийн үйл ажиллагааг тэтгэсэн татварын таатай орчинг бий болгоно.



2.3. Зохистой, хяналттай мөнгөний бодлого

Бодит байдал

Монголбанк “Үнэ тогтвортжуулах хөтөлбөр” нэрийдлээр “өөрсдийн” цөөн хэдэн компаниудад хөнгөлөлттэй зээл олгож зах зээлийг гажуудуулсан.

Монголбанк хууль зөрчиж, эрх баригчдын “бэлэн мөнгөний няраэ”-ын үүрэг гүйцэтгэж, улс төрийн үйл ажиллагаанд хутгалдан орсноор бие даасан, хараат бус байдлаа алдлаа.

Монгол Улсын гадаад валютын цэвэр албан нөөц 2012 оны эхний хагас жилд 2,7 тэрбум ам.доллар буюу импортынхоо 5 сарын хэрэглээг хангах хэмжээнд хурч байсан. Гэтэл өнөөгийн байдлаар Монгол Улсын гадаад валютын нөөц шавхагдлаа.

Монгол Улсын зээлжих зэрэглэл 2012 оноос хойш 3 шатлал буурсан нь гадаад зах зээлээс бага хүйтэй зээл авах боломжгүй болголоо. Тухайлбал, 2012 онд “Чингис” бондын 500 сая ам.долларыг жилийн 4,1 хувийн хүүтэйгээр зээлж байсан бол, өнөөдөр Засгийн газар 5 жилийн хугацаатай 500 сая ам.долларын бондыг жилийн 10,9 хувийн хүүтэйгээр арилжаалсан байна. Алдаатай мөнгөний бодлогын уршигаар төгрөгийн ханиш 2012 оноос хойш 50 гаруй хувиар суларч, МОНГОЛ ТӨГРӨГ үнэгүйдсээр байна.

Бид ингэж шийднэ

- 2.3.1. Монголбанкны үйл ажиллагааны алдаатай бодлогыг залруулж, хуульд заасан чиг үүргийнхээ дагуу хараат бусаар ажиллах нөхцөлийг хангана.
- 2.3.2. Монголбанк мөнгөний зохистой бодлогыг хэрэгжүүлснээр: (i) зээлийн хүүг бууруулна; (ii) валютын нөөцийг нэмэгдүүлнэ; (iii) инфляцийн түвшинг нэг оронтой тоонд барина; (iv) Монгол төгрөгийн ханшийн уналтыг зогсоож, зохистой түвшинг хадгална.
- 2.3.3. Засгийн газрын олон төрлийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор Монголбанкнаас арилжааны банкуудад их хэмжээний мөнгийг хууль бусаар байршуулдгийг зогсоон.
- 2.3.4. Иргэндээ ээлтэй, эдийн засагтаа үр өгөөжтэй банк санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, иргэдийн худалдан авах чадварыг нэмэгдүүлнэ.
- 2.3.5. Эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг сайжруулж, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг тогтвортжуулах, цаашид нэмэгдүүлэх замаар гадаадын хөрөнгө оруулагчдын алдарсан итгэлийг дахин сэргээж, хөрөнгө оруулалтын урсгалыг буцаан татна.

2.4. Уул уурхайн хөгжил

Бодит байдал:

2012 онд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 4,7 их наяд төгрөгт хурч байв. 2015 онд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 1,2 их наяд төгрөг болж 4 дахин буурлаа. Тавантолгой, Оюутолгой, бусад томоохон төслийдийн үйл ажиллагаа гацаа. БНХАУ-ын “Чалко” компанийд урт хугацааны гэрээгээр нүүрсээ 70 ам.доллараар нийлүүлэх байсныг “ашиггүй” хэмжээн цуцалж, өнөөдөр 30 хүрэхгүй ам.доллараар гүйж өгч байна.



Бид ингэж шийднэ

- 2.4.1. Байгалийн баялгийг боловсруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн болгон дэлхийн зах зээлд гаргах, дэлхийн нэр хүндтэй томоохон компаниудыг урьж ажиллуулах эдийн засаг, эрх зүйн нэн тааламжтай орчныг бүрдүүлнэ.
- 2.4.2. Уул уурхайн бодлогын судалгааны төв, гео мэдээллийн нэгдсэн сан бий болгож, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгоно.
- 2.4.3. Иргэн бүрийн эзэмшиж буй 1072 хувьцааг амь оруулж, үнэ цэнэтэй болгоно.
- 2.4.4. Уул уурхайн салбараас орох орлогыг одоо болон ирээдүй хойч үедээ тэгш хүртээх, оновчтой хуваарилах эрх зүйн орчин бүрдүүлж, “Баялгийн сангийн тухай” хуулийг батална.
- 2.4.5. Төрийн өмчит “Эрдэнэс Монгол” компанийн үйл ажиллагааг сайжруулж, Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэт зэрэг томоохон компаниудын үр ашгийг иргэн бүрт хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлнэ.
- 2.4.6. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль журмыг чанд мөрдүүлж ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.
- 2.4.7. Уул уурхайн олборлолтын төсөлд төрийн оролцоог зохистой байлгаж, татвар болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр авах хэлбэрийг сонгох бодлого тулхүү баримтална.
- 2.4.8. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэх, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.
- 2.4.9. Бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг Монголбанкны ханшаар худалдан авах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Хөгжлийг тэтгэгч-Дэд бүтэц

Бодит байдал:

Дэд бүтцийн томоохон төслүүд гацаанд оров. Тавантолгой-Гашуун сухайтын төмөр замыг төр хийх нэрийдлээр өнөөг хүртэл гацаалаа. Хөгжлийн банкнаас 250 сая ам.доллар зарцуулсан ч өнөөдөр 1 метр ч төмөр зам тавигдсангүй. Төмөр замаа хурдан барьж чадахгүй байгаа нь нуурсний өрсөлдөх чадварт маш их сэргээр нөлөөлж байгаа билээ. 2011 оны 6 дугаар сард шавьг тавьсан V ДЦС-ыг барьж ашиглалтанд оруулахын битгий хэл бүтээн байгуулалтын ажлыг нь ч өнөөг хүртэл эхлүүлээгүй байна.


2012 онтой харьцуулахад төмөр замын тээврийн ачаа тээвэрлэлт 6.4, зорчигчдын тоо 30 хувиар буурав. Мөн агаарын тээврийн ачаа тээвэрлэлт 28, зорчигчдын тоо 20 хувиар багаслаа. Олон арван тээврийн компаниуд дампуурч, машин техник нь банкны барьцаанд хураагдлаа.

Бид ингэж шийднэ

- 2.5.1. Улс орны өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэгцээг тасралтгүй, найдвартай хангаж, цаашид эрчим хүч экспортлогч орон болно.
- 2.5.2. Улаанбаатарын V дулааны цахилгаан станц, Тавантолгой, Баганур, Бөөрөлжүүт, Тэвшийнговийн дулааны цахилгаан станцуудыг барина.
- 2.5.3. Шивээ-Овоогийн ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төсөл хэрэгжүүлж эхэлнэ.
- 2.5.4. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж нар, салхин цахилгаан станц, Эгийн гол болон Ховд голын усан цахилгаан станцуудыг барина.
- 2.5.5. Баганур-Чойр, Улаанбаатар-Мандалговь, Баганур-Улаанбаатар, Баганур-Өндөрхаан-Чойбалсан, Чойр-Сайншанд, Мандалговь-Арвайхээр, Дөргөн-Улиастай-Улаанбаатарын бүс нутгийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.5.6. Аймгийн төвүүд болон томоохон хот сууринд дулааны станц шинээр барих, өргөтгөх, гэр хорооллын айл өрхүүдийг цэвэр бохир усны шугамд холбох ажлыг концессын гэрээгээр үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.5.7. Сумдыг төвлөрсөн дэд бүтэц буюу дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээтэй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.5.8. Дулаан, цахилгааны үнийг тогтвортой байлгаж цаашид үе шаттайгаар бууруулах бодлого барина.
- 2.5.9. Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, бүх аймгийн төвийг нийслэл хоттой авто замаар холбож дуусгана.
- 2.5.10. “Ухаа худаг-Гашуун сухайт”, “Нарийнсухайт-Шивээхүрэнгийн” чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтанд оруулна.
- 2.5.11. “Эрдэнэт-Овоот”, “Богд хаан” төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлж, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлнэ.
- 2.5.12. “Хөшиг”-ийн хөндийд тээвэр ложистикийн төв байгуулна.
- 2.5.13. Агаарын тээврийн салбарын уналтыг зогсоож, дотоод, гадаадын сүлжээг нэмэгдүүлэн, орон нутаг, олон улсын нислэгийн үнэ тарифыг бууруулна.
- 2.5.14. Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшигаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн түргэн тусlamжийн үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын зэрэг салбарт ашиглана.

2.6. Импортлогч орноос-Экспортлогч орон

Бодит байдал:




Манай улс нийт хэрэглээнийхээ 88 хувийг гаднаас импортлон авч, үлдсэн 12 хувийг өөрсдөө үйлдвэрлэж байна. 56 сая малтай боловч жилд 56 тэрбум төгрөгийн суу, сүүн бүтээгдэхүүнийг импортоор авч хэрэглэдэг. 2015 онд экспортын орлогын 78,8 хувийг уул уурхайн салбар бүрдүүлэв. Аж үйлдвэрлэл хөгжсөн улс орнуудад Боловсруулах аж үйлдвэрийн салбар ДНБ-ийхээ 30-40 хувийг эзэлж байхад, манай улсад ердөө 10 хувьд ч хүрэхэй байна.

Манай улс 1990 оноос өмнө олон зуун үйлдвэр, аж ахуйн газартай байсан бөгөөд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудад арьс шир, савхи боловсруулах үйлдвэр, үслэг эдлэлийн үйлдвэр, ноос, сүлжмэлийн үйлдвэр, мах сүүний комбинат, аймаг бүрт хүнсний үйлдвэр, мод боловсруулах үйлдвэр үйл ажиллагаа явуулж байв.

Бид ингэж шийднэ

- 2.6.1. Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, үйлдвэржилтийн бодлогыг тодорхой болгоно.
- 2.6.2. Дотооддоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, ДНБ-д эзлэх хувийг 20 хувьд хүргэнэ.
- 2.6.3. Оюутолгой, Эрдэнэт, Цагаан Суварга зэрэг ордуудыг түшиглэн зэс хайлуулах, Тавантолгойн ордыг түшиглэн нүүрс угаах, цаашид гүн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 2.6.4. Төмөртэй, Төмөр Толгой зэрэг ордуудыг түшиглэн Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөг, металлургийн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 2.6.5. Нүүрс, занар, газрын тос боловсруулах, шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах, газрын тос, кокс-хими, химиин шинэ хүчин чадлуудыг бий болгож, дотоодын хэрэгцээгээ хангахыг дэмжиж ажиллана.
- 2.6.6. Ажлын байрыг хамгийн олноор бий болгодог хөнгөн үйлдвэрийн салбарыг сэргээн хөгжүүлэх “21:100” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 21 аймагт импортыг орлох, гол 100 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 2.6.7. Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг “Эх оронч” дотоодын худалдан авалтаар дэмжих хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжүүлнэ.
- 2.6.8. Томоохон үйлдвэрлэл явуулж буй аж ахуй нэгжүүдэд олгож буй зээлийн хугацааг уртасгаж, хүүг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.
- 2.6.9. Бус нутагт байгуулагдах боловсруулах үйлдвэрүүдийг сайн засаглалтай байлгаж, орон нутгийн бизнес эрхлэгч, ард иргэд, малчдад нээлттэй байлгах бодлого баримтлана.
- 2.6.10. Импортын барааны татварыг үе шаттай нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэлээ дэмжинэ.
- 2.6.11. Үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгааны тарифыг бууруулах замаар бүтээгдэхүүний өртийг багасгах бодлого хэрэгжүүлнэ.



- 2.6.12. Гадаад зах зээлд экспортлох боломжтой тэргүүлэх ач холбогдолтой бараа бүтээгдэхүүний судалгаа, маркетингийг төрөөс дэмжиж, “Монгол экспорт” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.6.13. Хөрш ОХУ, БНХАУ-тай хийх чөлөөт худалдаа, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг өргөжүүлэн, хорио цээрийн нөхцөлийг сайжруулах, гаалийн тарифыг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.
- 2.6.14. Үйлдвэрлэлийн салбарын боловсон хүчинийг сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлнэ.
- 2.6.15. Экспортын нэг цонхны бодлого хэрэгжүүлж, гааль, татвар, мэргэжлийн хяналт зэрэг төрийн үйлчилгээг нэг цэгт үзүүлж, чирэгдлийг багасгана.

2.7. Хувийн хэвшил- Ажлын байр

Бодит байдал

Бодлогын алдааны уршигаар иргэд, аж ахуйн нэгжийн ашиг орлого буурч, бизнес эрхлэх орчин улам бүр муудлаа. Монгол Улсад бүртгэлтэй байсан 126 мяняга гаруй аж ахуйн нэгжээс 2015 оны эцсийн байдлаар 62,3 мяняга гаруй нь үүд хаалгаа хаасан байна. Үүнээс үүдэн ажлын байр хомсдож, ажилгүйдэл нэмэгдлээ. 2012 онд ажил хайж байгаа 2 хүний нэг нь ажилд орж байсан бол одоо 7 хүний 1 нь арай ядан ажилд ордог боллоо.

Ажиллагсдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээ аваагүйн дээр ажилгүйдэл өссөн, орлого буурсан. 2012 онд өрхийн мөнгөн орлого 40 хувиар нэмэгдэж байсан бол 2015 онд 13 хувиар буурсан байна.

Эрх баригчид татвар, хураамж, торгуулийг нэмж иргэд, аж ахуйн нэгжээ дарамтлан, халаасыг нь тэмтрэх болсны илрэл нь улсын нэгдсэн төсөвийн хүү, торгуулийн орлого сүүлийн 4 жилд бараг 4 дахин нэмэгдсэн байна.

Бид ингэж шийднэ

- 2.7.1. Эрх бүхий байгууллагуудаас үндэсний аж ахуйн нэгжүүдэд тавигдсан татварын актын хүү, торгууль, алданги, үндсэн татварын нөхөн төлбөрийг төлөх хугацааг сунгах, хаалгасан дансыг нь нээх зэргээр бизнес эрхлэгчдээ дэмжинэ.
- 2.7.2. Эдийн засгийн хямрал хүндрэлээс улбаалан ажил, орлого нь хумигдан, зээлээ төлж чадахгүйд хүрч, “Найдваргүй зээлдэгчдийн жагсаалт”-д бүртгэгдсэн аж ахуй нэгж, иргэдэд зээлээ эргэн төлж, зээлийн түүхээ сайжруулах боломж олгоно.
- 2.7.3. Дотооддоо санхүүгийн хуримтлал үүсгэхэд чиглэсэн урт хугацааны даатгал, хамтын хөрөнгө оруулалтын сан эрхлэх зэрэг аливаа санал санаачилгыг бүхий л талаар дэмжиж, санхүүгийн зах зээлийг олон тулгууртай болгон хөгжүүлнэ.
- 2.7.4. Шинэ төрлийн татвар бий болгохгүй ба жилийн орлого нь 1,5 тэрбум тэгрэгээс бага орлоготой аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь болгон бууруулах бодлого баримтлана.



- 2.7.5. Барилга болон бусад салбарын төрөөс авч чадахгүй байгаа гүйцэтгэсэн ажлын хөлсийг нь олгуулах талаар арга хэмжээ авч, эрх зүйн орчныг сайжруулна.
- 2.7.6. Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог 3 дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгана.
- 2.7.7. Бизнесийн орчин дахь төрийн оролцоог багасгаж, төр хувийн хэвшилтэй өрсөлдөж, бизнес эрхэлдэг явдлыг таслан зогсооно.
- 2.7.8. Үндэсний хөрөнгө оруулагчдыг бүхий л талаар дэмжиж, шинэ хөрөнгө оруулалтыг эхний хөрөнгө оруулалтаа нөхөх хүртэлх хугацаанд орлогын албан татварыг хөнгөлөх эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 2.7.9. Хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт бизнес эрхлэлтийг дэмжих “Бүсийн хөнгөлөлтийн” бодлого хэрэгжүүлнэ.
- 2.7.10. ЖДҮ эрхлэгчид, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд зориулсан таатай нөхцөл бүхий “Итгэлийн зээл” олгох бодлого баримтална.
- 2.7.11. Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан бууруулахын зэрэгцээ, улсын хэмжээнд ижил үнэтэй байлгаж, үнийн дарамтыг бууруулна.
- 2.7.12. Эдийн засгийн интеграцилалд нэгдэн орсноор Монгол Улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж, бүс нутгийн дэд бүтцийн сүлжээнд хамрагдана.
- 2.7.13. Жижиг дунд бизнес эрхлэгч нь 5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр бий болгосон бол урт хугацаат, хөнгөлөлтэй зээлээр дэмжих бодлого баримтална.

2.8. Газар тариалан- Экологийн эрүүл хүнс

Бодит байдал:

ХАА-н салбарын төрийн бодлого алдагдсанаар “Атрын аян”, “Монгол мал” зэрэг үндэсний хөтөлбөрүүдийн үр өгөөж, ололт амжилт нь үгүй болж, хүнсний аюулгүй байдал алдагдах хэмжээнд хурлзээ.

2012 онд МАН-ыг засаг барьж байхад Монгол Улс жилдээ 447 мянган тонн үр тариа, 202 мянган тонн төмс, 99 мянган тонн хүнсний ногоо, 47 тонн гар тэжээл хураан авч дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, гадаад зах зээлд 100 мянган тонн улаан буудай экспортлох хэмжээнд хүрч байв. Гэтэл сүүлийн 4 жилд газар тариалангийн салбар бүрэн уналтад орж 2010 оныхос 5 дахин бага үр тариа, 2 дахин бага төмс, 2 дахин бага хүнсний ногоо, 4 дахин бага тэжээл хураан авч дотоодын хэрэгцээнийхээ 50 хувийг ч хангаж чадахгүй хэмжээнд хүрч доройтлоо. Сүүлийн 2 жилд импортоор 190 гаруй мянган тонн үр тариа авахад хүрч газар тариалангийн салбар уналтад орлоо.



Бид ингэж шийднэ

- 2.8.1. Газар тариалангийн бүс тогтоож, тухайн бүсэд тариалан эрхлэлтийг эрчимжсэн мал аж ахуйтай зохистой хослуулан хөгжүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг 4 дахин нэмэгдүүлэн, хүн амаа шим тэжээллэг, аюулгүй хүнсээр жигд хүртээмжтэй хангана.
- 2.8.2. “Атрын аян”-ыг үргэлжлүүлж, газар тариалангийн эргэлтийн талбайг 2 дахин нэмэгдүүлнэ.
- 2.8.3. Газрын үржил шим, үр өгөөж, таримал ургамалын үр үржүүлгийн аж ахуйг цогцолбор байдлаар хөгжүүлж, үрийн сорт чанарыг сайжруулах замаар гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэн, усалгаатай талбайн хэмжээг 4 дахин өсгөнө.
- 2.8.4. “Ногоон хэрэм” хөтөлбөрийг хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсийг салхины элэгдлээс хамгаалах арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлнэ.
- 2.8.5. Хүнсний ногоо, жимс жимсгэний нэр төрлийг нэмэгдүүлэн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, борлуулалтын нэгдсэн сүлжээ байгуулна.
- 2.8.6. Дотоодын хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшуулж, тахиа, гахай, зөгий, загасны аж ахуй зэрэг дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.8.7. Иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг сайжруулна.
- 2.8.8. Газар тариалангийн түүхий эд, материал, тоног төхөөрөмжийг татварын бодлого, санхүүгийн лизингийн арга хэрэгслээр дэмжиж, агуулах, зоорь, хүлэмжийн аж ахуйг өргөтгөнө.
- 2.8.9. Тариалангийн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.

2.9. Монгол малчин

Бодит байдал

Малчдын маань хөдөлмөр зүтгэлийн үр дүнд мал сүрэг 56 сая тоо толгойд хүрлээ. Гэвч сүүлийн жилүүдэд мал, малчдын хөдөлмөр үнэгүйдлээ. 2011-2012 онд 10-13 мянган төгрөг хүрч байсан хонины нэхийн 500 төгрөг болж 20-26 дахин буурлаа. 2012 оноос өмнө жилдээ 24 мянга орчим тонн мах гадаад зах зээлд гаргаж байсан бол 2015 онд 2 мянган тонн мах экспортлож, бараг 12 дахин буурчээ.

Бид ингэж шийднэ

- 2.9.1. “Max, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж нийслэл, хот суурин газрын хүн амыг эрүүл, аюулгүй, экологийн цэвэр мах, сүүгээр хангана.



- 2.9.2. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг зохистой хослуулснаар мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, жилд экспортлох хэмжээг 50 мянган тоннд хүргэж, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.9.3. Малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас малчдад ирж буй хундрэлийг багасгахад чиглэгдсэн тусгай сан байгуулан, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангаж, эрсдлийг бууруулах арга хэмжээ авна.
- 2.9.4. Малчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, малчинд ээлтэй зээлийн үйлчилгээг нэвтрүүлэх эрх зүйн орчин бурдүүлэх замаар зээлийн хүүгийн дарамтыг бууруулна.
- 2.9.5. Орон сууцны хөтөлбөрт малчдыг хамруулах, нийгмийн асуудлыг шийдэх арга хэмжээ авна.
- 2.9.6. Малчдын тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулна.
- 2.9.7. Малчид, хувиараа аж ахуй эрхлэгчдэд нийгмийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх эрх зүйн орчин бий болгоно.
- 2.9.8. Малчин, тариаланчдын хоршоог төрөөс зээл, хөрөнгө оруулалт, татварын бодлогоор онцгойлон дэмжиж өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хөдөө аж ахуйн хоршооны шинэ эрх зүйн орчныг бурдүүлнэ.
- 2.9.9. “Малжуулах хөтөлбөр”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлж, малчдыг дэмжих бодлого баримтална.
- 2.9.10. Малын даатгалын тогтолцоог өргөжүүлж, малчдад учрах эрсдлийг бууруулна.
- 2.9.11. Малын хулгайн гэмт хэрэгт оногдуулах шийтгэлийг чангатгана.
- 2.9.12. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, зах зээлд нийлүүлэх тогтолцоог хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржтэй уялдуулан хөгжүүлнэ.
- 2.9.13. Малыг бүртгэлжүүлж, сум бүрт мал нядалгааны цех байгуулах замаар малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгоно.
- 2.9.14. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, малыг эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний чадавхийг бэхжүүлэхэд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
- 2.9.15. Малын чанарыг сайжруулах, цөм сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх, үржил селекц, зоотехникч, малын эмч бэлтгэх, давтан сургахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.9.16. Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах үйл ажиллагаанд зээлийн дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлнэ.
- 2.9.17. Хөдөөгийн хүн ам болон мал аж ахуйн усан хангамжийг сайжруулах замаар бэлчээрт худаг, хөв цөөрөм барьж байгуулна.
- 2.9.18. Бэлчээрийг сэлгээтэй ашиглаж, бэлчээрийн талхагдал, цөлжилтийг бууруулж, бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч амьтантай байгаль орчинд халгүй арга, дэвшилтэт технологи ашиглан тэмцэж, бэлчээр ашиглалтыг сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүртээмж, ашиглалтыг сайжруулна.



ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1. Хүний эрүүл мэнд, байгальд ээлтэй ногоон хөгжил

Бодит байдал

2012 оны 5 дугаар сард УИХ-аас батлагдсан Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх ажлыг орхиудуулан “байгальд ээлтэй технологи, цэвэр үйлдвэрлэл, ногоон хэрэглээг урамшуулах” амалалтадаа хэрэгжүүлээгүйгээс уул уурхайн олборлолт байгаль орчин, гол усыг бохирдуулан, хууль бус ан аганалт, мод бэлтгэл дорвигийн зогсохгүй, хүний оролцоотой ой хээрийн түймрийн тоо нэмэгдэж байна.

Бид ингэж шийднэ


- 3.1.1 Байгалийн унаган төрх, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээж, усны нөөцөө хамгаалах, хомсдлоос сэргийлэх, байгаль орчинд нийцтэй тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ.
- 3.1.2 Байгалия хамгаалах, түүний нөөцийг ашиглах, нөхөн сэргээх ажлыг иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлж, олгох урамшууллыг тодорхой болгоно.
- 3.1.3 Хүний эрүүл мэнд, байгальд ээлтэй дэвшилтэй технологийг нэвтрүүлж, нөөцийг аль болох хэмнэж, бага хэрэглэх, дахин ашиглах, дахин боловсруулан ашиглах ногоон эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.1.4 Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжиж, нүүрс ашиглах шинэ технологи нэвтрүүлэн, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан үйлдвэрлэл, бизнесийг олон улсын гэрээ хэлэлцээр, бодлогын зорилт, стандарт шаардлагын хүрээнд дэмжинэ.
- 3.1.5 Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтанд тавих хяналтыг сайжруулна.
- 3.1.6 Ой, байгалийн бусад нөөцийн дагалдах баялгийг ашиглаж, экологийн цэвэр түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.2 Экосистем, унаган байгалийн тогтвортой байдал

Бодит байдал

Эрх баригчид “газрын харилцааны шинэчлэл хийх” нэрийдлээр “Газрын тухай багц хуулийг шинэчлэх” төслийг УИХ-д оруулж, түүндээ эх орныхоо газар нутгийг гадаадынханд дуудлага худалдаагаар урт хугацаагаар эзэмшүүлэх тухай алдаатай бодлого тусгасныг МАН таслан зогсоосон. Цөлжилтөөс сэргийлж, бэлчээрийн талхлалтыг бууруулах, бэлчээр, усны цогц бодлого хэрэгжүүлээгүйгээс нийт бэлчээрийн 70 гаруй хувь талхлаадж, цөлжилт эрчимжиж байна.

Мөн “Гол, мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай газарт хамруулах” хуулийн заалтыг удаа дараа зөрчин, хэлбэр хэмжээг өөрчлөн нэгдсэн зураалт гаргах ажил 4 жил дараалан сунжирч байна. Үүний улмаас “улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх”, “томоохон гол, мөрнүүдийн урсацын тохиргоо хийж, усан сан байгуулж, бус



нутгийн хэрэгцээг хангах" амлалтуудаа биелүүлсэнгүй.

Бид ингэж шийднэ

- 3.2.1 Бохир усыг цэвэршүүлэн ашигладаг технологийг нэвтрүүлж, усны нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх замаар усны хомсдоос сэргийлнэ.
- 3.2.2 Байгалийн унаган төрхийг хадгалсан газар, цэнгэг усны нөөц, томоохон гол, мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалж, хамгаалалттай газар нутгийн эзлэх хэмжээг 2020 онд нийт нутаг дэвсгэрийн 25-иас доошгүй хувьд хүргэнэ.
- 3.2.3 Гол, горхи, булаг шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол, мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах сан байгуулж, усан хангамжийг нэмэгдүүлнэ.
- 3.2.4 Нийслэл, төв суурин газрын ундны усны эх үүсвэрийг хамгаалах арга хэмжээ авна.
- 3.2.5 Газрын нэгдсэн бодлого, тогтолцоог бүрдүүлж газрыг ашиглах, эзэмших, иргэдэд өмчлөх эрх зүйн харилцааг шинэчилж, эдийн засгийн эргэлтэд оруулна.
- 3.2.6 Уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээх ажлыг орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор бүрэн хийлгэнэ.
- 3.2.7 Устах аюулд орсон болон аж ахуйн гоц ашигт амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэн, сэргээн нутагшуулах, тарьж ургуулах ажлыг хөрөнгө, санхүү, татварын бодлогоор дэмжинэ.

3.3 Байгаль хамгаалалд -бүх нийтийн оролцоо

Бодит байдал

Эрх баригчид 4 жилийн өмнө өгч байсан "орон нутаг дахь иргэний байгууллага, иргэдийн нөхөрлөлтэй байгаль хамгааллын чиглэлээр хамтран ажиллах тогтолцоог шинэ шатанд гаргах" зорилтоо хэрэгжүүлсэнгүй. Улсын хэмжээнд 1700 орчим байгаль хамгаалах нутгийн иргэдийн нөхөрлөл байгуулагдан 40,000 гаруй гишүүн ажиллаж байгаа хэдий ч эрх зүй, зохион байгуулалтын тогтолцоонд ямар нэг ахиц гарсангүй.

Бид ингэж шийднэ

- 3.3.1 Байгаль хамгаалах нутгийн иргэдийн нөхөрлөпүүдийн байгалийн баялгаа давуу эрхээр ашиглах, нөхөн сэргээх ажлыг эрхлэх эрх зүй, эдийн засгийн орчныг бүрдүүлэх замаар орон нутагт ажлын байр, орлогын нэмэлт эх үүсвэрийг бий болгоно.
- 3.3.2 Иргэн, иргэдийн нөхөрлөл аж ахуйн нэгж, байгууллага тарьж ургулсан ой, ургамал, өсгөж үржүүлсэн ан амьтан болон хурын усныг хуримтлуулах



замаар нуур, цөөрөм, усан санг бий болгосон тохиолдолд урамшуулах эрх зүйн орчныг бий болгоно.

- 3.3.3 Ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт зэрэг байгалийн гамшгаас сэргийлэх, болзошгүй эрсдлийг бууруулах ажлын шинэ менежментийг нэвтрүүлнэ.

3.4 Аялал жуулчлал- Соёлын гуур

Бодит байдал

Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн гол чиглэлийн нэг гэж үзэн төрийн тогтвортой бодлого шийдвэрээр дэмжиж хөгжүүлэлгүй, хувийн хэвшлийн “сайн дурын” асуудал мэт үзэж, аль нэг яамны “хавсарга” болгон орхиадуулж ирсэнээс өнгөрсөн 4 жилд энэ салбарт ямарч ахиц, дэвшил гарсангүй. 2015 онд манай улсад ирсэн гадаадын жуулчдын тоо өмнөх онуудын дунджаас 15 орчим хувиар буурсан байна.

Бид ингэж шийднэ

- 3.4.1 Аялал жуулчлалын салбарын хөгжлийг хангах олон улсын болон бус нутгийн сүлжээнд нэгтгэх, дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулж, аялал жуулчлалын салбараас иргэд, ААН-ийн олох орлогыг нэмэгдүүлэх цогц бодлого хэрэгжүүлнэ.
- 3.4.2 Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, онгон байгалийг түшиглэсэн дотоод, гадаадын аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, аймаг, бус нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 3.4.3 “Бурхан халдун”, “Хорго-Тэрх”, “Хамарын хийд”, “Отгонтэнгэр”, “Хар-Ус”, “Хөвсгөл”, “Хар хорин”, зэрэг байгалийн үзэсгэлэнт, өвөрмөц тогтоц бүхий газар нутагтаа түшиглэсэн түүхэн болон төрөлжсөн аялал жуулчлалын төв, цогцолборыг аймаг бүрт байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 3.4.4 Монгол Улсынхаа давуу тал, аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүнийг зорилтолт улс орнуудад сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, Монгол улс руу болон гадагшаа чиглэсэн олон улсын нислэгийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэн гадаадын жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.
- 3.4.5 Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор зах зээлийн эрэлтэд нийцсэн парк, музей цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтаар барьж, байгуулахыг дэмжинэ.
- 3.4.6 Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу зогсоол, үйлчилгээний төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахыг дэмжинэ.

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1 Төлөвшсөн эрх зүйт төр- тогтвортой, хариуцлагатай засаглал

Бодит байдал:

Монгол Улсад Үндсэн хуулийг үл хүндэтгэсэн, бүдүүлгээр зөрчсөн, арчиллын үнэт зүйлсийг уландаа гишгэсэн үйл явдал хэвийн үзэгдэл болж, улс төрийн дарангуйлал тогтлоо. Үндсэн хуульт ёс алдагдан төрийн дээр нам, фракцийн эрх ашиг тавигдаж арчилал, улмаар иргэний эрх, эрх чөлөөнд аюул учирлаа.

Хуурамч арчиллыг устгаж, дүр эсгэсэн арчиллаас жинхэнэ арчиллын ололт, үнэ цэнийг хамгаалах зайлшгүй цаг үе тулаад байна. Монгол Улсад Үндсэн хуулийн хямрал бодитой нүүрлээд байна. Улсын Их Хурал, Засгийн газрын эрх мэдлийн зааг ялгаа алдагдаж “давхар дээл” нэмэрсэн эрх мэдэлтнүүд төрийн үйл ажиллагааг хувийн эрх ашгийн төлөө хуульгүй мэт удирдаж байна.

Хууль дээлэх зарчим бүрэн алдагдаж эрх мэдэлтнүүдийн дур зоргоороо авирлах явдал газар авлаа. Үндсэн хуулийн манаач болсон Үндсэн хуулийн цэцийг хүртэл эрх баригч хүчин өөрсдийн харцаар хөдөлгөхийг хүсч байна. Үндсэн хуулийг шинэчлэн баталсан 1992 оноос хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлүүлэхээр иргэдээс гаргасан өргөдлийн 70 орчим хувийг 2012 оноос хойш гаргажээ.

2008 оны Засгийн газрын бүтэц цомхон, оновчтой буюу 11 яам, 14 сайд, 12 дэд сайдтай байсан бол 2012 онд бүрдсэн Засгийн газар 16 яам, 19 сайд, 17 дэд сайдтай болж хэт данхайж, чиг үүрэг нь давхардаж “Бийд нэмэргүй, байхгүйд гарзгүй” албан тушаалтнуудаар төрийн алба дүүрлээ. УИХ-ын гишүүд олноороо “давхар дээл” нэмэрснээр төр засгийн ажил цалгардаж “Их ажлын дүр, ид ажлын садаа” болон хувирлаа.

Бид ингэж шийднэ

- 4.1.1 Эрх мэдлийн харилцан хяналт, тэнцэлтэй, тогтвортой, хариуцлагатай төрийг бий болгохын төлөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан ард түмнээсээ асууж шийдвэрлэнэ.
- 4.1.2 Төрийн эрх мэдлийн хуваарилалтыг оновчтой болгож, хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүргийг тодорхой зааглана.
- 4.1.3 УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүнээр давхар ажиллахыг хязгаарлана.
- 4.1.4 Парламентын засаглалыг бэхжүүлж, улс төрийн намуудын шинэ соёл, ёс суртахуун, төлөвшлийг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 4.1.5 Улс төрийн намын үйл ажиллагаа болон санхүүжилтийг ил тод, хяналттай болгож, бизнесийн бүлэглэлийн нөлөөллийг таслан зогсооно.
- 4.1.6 Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах хүрээнд салбар бүрт батлагдан хэрэгжиж буй бодлогын уялдаа холбоог хангаж, боловсронгуй болгон үргэлжлүүлнэ.
- 4.1.7 Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ.



- 4.1.8 Зөвлөлдөх ардчилал, ард иргэдийн оролцоог дэмжих “Ардын засаглал” хөтөлбөр хэрэгжүүлнэ. Монгол Улсад Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэсэн Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийг баримтлан ухамсартай ардын үг, зөвлөлдөх ардчиллын санал асуулгаар төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

4.2 Иргэндээс ойр- Төрийн үйлчилгээ

Бодит байдал

Төрийн захиргааны болон үйлчилгээний шат шатны байгууллагад хариуцлагагүй байдал газар авч, мэргэшсэн төрийн албан хаагчдыг ажлаас халах замаар төрийн албаны залгамж, мэргэшсэн чанарыг алдагдууллаа. Намын харьяаллаар иргэдээс ялгаварлан гадуурхдаг байдал газар аелаа.

Төрийн албан хаагчдын тоо 167800 болж, төрийн өмчтүүлж аж ахуйн нэгжид ажиллагсдын тоо 49600 болж нэмэгдлээ. Энэ байдалд дүгнэлт хийсэн Төрийн албаны зөвлөл 2015 онд анх удаа төрийн албан хаагчдын тогтвортгүйтэл үндэсний аюулгүй байдалд заналхийлэх хэмжээнд хүрснийг тайлагнав.

Төрийн ажлын мэдлэг туршиллагагүй, зөв хандлагагүй хүмүүсийг төрийн захиргааны албан тушаалд томилж, бодлогын алдаа хийсэн нь өнгөрсөн 4 жилд эдийн засаг, нийгмийн амьдралд бий болсон сөрөг үр дагаваруудын үндсэн шалтгаан болжээ. Тэр битгий хэл өөрсдийн төрөл садан, ах дүүгээр төрийн албыг залгуулах бүдүүлэг хандлагыг тогтоогоод байна.

Бид ингэж шийднэ

- 4.2.1 Төрийн байгууллагуудын ажил үүргийн давхардлыг арилгах, нэгтгэх замаар яам, агентлаг, төсвийн байгууллагуудын тоог цөөлж, оновчтой бүтцийг бий болгоно.
- 4.2.2 Төрийн захиргааны албан тушаалын сонгон шалгаруулалт, тохоон томилох, байршуулах, сэлгэн ажиллуулах, дэвшүүлэх үйл явцад нийгмийн бүлгүүдийн эрх ижил тэгш хангагдах зарчим баримтална.
- 4.2.3 Төрийн албан хаагчдыг урт хугацааны цогц даатгалд хамруулах замаар тэдгээрийн нийгмийн хамгааллыг сайжруулна.
- 4.2.4 Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.2.5 Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг шинэчлэн иргэдэд зүй бусаар хандсан, хүнд суртал гаргасан, худал мэдээлэл хийсэн тохиолдолд хууль зүйн хариуцлагын арга хэмжээ авдаг болно.
- 4.2.6 Мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувьд шаардлага хангахгүй, хариуцлага алдаж ёс зүйн алдаа гаргасан төрийн бүхий л шатны албан тушаалтыг ар, өврийн хаалга, танил тал, нам эвслийн эрх ашиг харгалзахгүйгээр хуулийн дагуу хариуцлага тооцож, төрийн албаны нэр хүндийг өргөнө.



- 4.2.7 Төрийн байгууллагыг удирдаж байгаа хүмүүс ах дүү, хамаатан саднаа ажилд авахыг хориглоно.
- 4.2.8 Төрийн албанда шат ахиулан албан тушаал дэвшиүүлэх Мерит тогтолцоог хэвшүүлнэ.
- 4.2.9 Төрийн аливаа шатны эцсийн шийдвэр гаргаж, албан ёсоор баталгаажуулж байгаа албан тушаалтны гаргасан шийдвэр хууль, шударга ёсыг зөрчин иргэн болон улсад хохирол учруулсан бол бүх хохирол, алдангийг төрөөр төлүүлдэг одоогийн журмыг өөрчилж тухайн албан тушаалтнаар өөрөөр нь төлүүлдэг эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 4.2.10 Төрийн албаны тогтвортой байдлыг баталгаажуулж, "Төрийн албан хаагчийн дархлааны тухай хууль"-ийг санаачлан батлуулна.
- 4.2.11 Төрийн албан хаагчдын цалинг үе шаттай нэмэгдүүлнэ.
- 4.2.12 Төрийн албан хаагчийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлж, нөхцлийг сайжруулах бодлого баримтална.
- 4.2.13 Төрийн үйлчилгээнд иргэдийн үнэлгээний картын системийг нэвтрүүлнэ.
- 4.2.14 Төрийн байгууллагуудын ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд иргэний нийгмийн төлөөллийг оролцуулна.
- 4.2.15 Төрийн үйлчилгээг "Цахим" хэлбэрт шилжүүлэх замаар иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэнэ.
- 4.2.16 Хөдөөгийн иргэдийн аюулгүй орчинд амьдрах Малчдыг мэдээллээр хангах (MMX хөтөлбөр) хэрэгжүүлж, сум, багийнхаа үйл ажиллагаанд орон зайн тэгш бус байдлаас үл хамааран жигд оролцох боломжоор хангана.
- 4.2.17 Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх бодлого барина.
- 4.2.18 Төрийн захиргааны албан тушаалтан ард иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх хугацааг хоёр дахин бууруулж, хөнгөн шуурхай болгоно.
- 4.2.19 Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил, тод болгож "Шилэн тендер" бодлого хэрэгжүүлнэ.
- 4.2.20 Төрөөс олгодог шагналын нэр хүндийг өсгөн, шалгуур үзүүлэлтийг хатуу мөрдүүлнэ.

4.3 Хараат бус, шударга хууль шүүхийн байгууллага

Бодит байдал

Шүүхийн шинэштээлийн бодлого ард, иргэдийн амьдралд сөрөөр нөлөөлөхийн зэрэгцээ тэнд ажиллаж байгаа албан хаагчид нь "хөл, толгойгоо мэдэхгүй", өөрсдөө будилсан хэвээр байна. Үүний нэг жишээ нь, давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахын тулд иргэд аймаг дамжин явдаг болсон нь иргэдэд зардал, чирээдэл учруулж төлбөрийн чадвар муутай иргэд давж заалдах эрхээ эдлэхгүй хохирч байна.



Албан тушаалтан эрх мэдэлтнүүд нь шүүхийн хариуцлагаас мултарч хулгай хийсэн хөрөнгөө зэйн засгийн ил тод байдал нэрээр хууль гарган хамгаалж байхад энгийн иргэд нь л зөвхөн ял зэм хүртдэг шударга бус явдал хэвийн үзээдэл болжээ.

Улс оронд ажилгүйдэл ядуурал газар авч ард, иргэдийн амьжиргаа эрс муудаж, өрөнд баригдаж улмаар гэмт хэргийн гаралт, гэр бүлийн хүчирхийлэл эрс нэмэгдэв. Олныг цочирдуулсан гэр бүл, үр хүүхдээ хөнөөх, банк дээрэмдэх зэрэг онц хэрцгий гэмт хэрэг өдөр тутам олноороо гарах боллоо. Гэмт хэргийн гаралт сүүлийн дөрвөн жилд 45 хувиар нэмэгдэв.

Бид ингэж шийднэ

- 4.3.1 Үндсэн хуулийн цэц, шүүхийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлж, шүүхийн үйл ажиллагааг нээлттэй ил тод болгоно.
- 4.3.2 Хууль тогтоомжоос үүдэлтэй иргэдийг хохироосон хууль сахиулах байгууллагуудын алдаа гажуудлыг засч, эрх зүйн орчныг нь иргэндээ ойртсон, тогтвортой болгоно.
- 4.3.3 Хууль алагчлалгүй үйлчлэх зарчмыг чанд баримтална. Хэн нэгэнд ялгавартай хандах, давуу байдал олгосон хуулийн байгууллагын албан тушаалтанд оногдуулах сахилгын, захиргааны болон эрүүгийн хариуцлагыг чангатгана.
- 4.3.4 Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчныг цогцоор нь бүрдүүлнэ.
- 4.3.5 Шүүгчийн сонгон шалгаруулах тогтолцоог боловсронгуй болгож, Шүүхийн захиргааны хуулийг шинэчилж сайжруулна.
- 4.3.6 Шүүгч бүр дээр хувийн хэрэг нээж, шийдвэрлэсэн хэрэг маргаан нь дээд шатны шүүхээр өөрчлөгдсөн тохиолдол бүрт зөрчлийн оноо тооцон хариуцлагыг дээшлүүлнэ.
- 4.3.7 Гэмт хэргийн гаралтыг бууруулах, гэрч хохирогчдыг хамгаалах зорилтыг эн тэргүүний бодлого болгоно.
- 4.3.8 Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг чангатгахын зэрэгцээ авлигын хэргээр ял шийтгэгдсэн этгээдийг дахиж төрийн албанад томилдоггүй байх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 4.3.9 Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг газар авахуулалгүй таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 4.3.10 Цагдаа ард иргэдтэйгээ хамтарч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөлт хөшүүрэг бүхий бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.3.11 Гэрч, хохирогчийг хамгаалах хуулийн хүрээнд мэдээллийг чандлан нууцлах зохицуулалтыг бий болгоно.

4.4 Иргэн хүний эрх, эрх чөлөө



Бодит байдал

Монгол Улсад хүний эрхийг дээдлэх Үндсэн хуулийн зарчим алдагдаж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх алдагдаж хөрсний бөхирдол, байгаль орчныг доройтлын улмаас хорт хавдар үүсгэх зэрэг өвчлөл эрс нэмээдлээ. Ихэнх бус нутагт агаар, орчноос хамаарсан өвчин нэг жилийн дотор 2.5 дахин өсч нас баралт жил тутам нэмээдсэн болохыг Хүний эрхийн үндэсний комисс тодорхойлж байна.

Иргэн, аж ахуйн нэгжийн өмчлөх эрхийн баталгаа алдагдаж эрх мэдлээр далайлган булаан авах, үндэслэлэгүй тorgууль, төлбөр авах яедал хэвийн үзээдэл болж ямарч хяналтгүй төрийн дарангуйлал газар авч, арчилал, улмаар иргэний эрх, эрх чөлөөнд аюул учирлаа.

Бид ингэж шийднэ

- 4.4.1 Орон нутагт гарч байгаа хүний эрхийн зөрчил, гомдлыг шуурхай шалгаж, шийдвэрлэх, хүний эрхийн төлөөлөгчийг томилж ажиллуулдаг болно.
- 4.4.2 Хэвлэлийн эрх чөлөөг хуулиар хамгаалж, хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг хязгаарласан аливаа бодлого хэрэгжүүлэхгүй.
- 4.4.3 Иргэд, хуулийн этгээдийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн баталгааг алдагдуулсан хууль тогтоомж, шийдвэрийг засаж сайжруулна.
- 4.4.4 Эрх олгох, хөндлөнгийн хяналт тавих зэрэг төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлнэ.
- 4.4.5 Хуулиар зөвшөөрсөн, өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд хувь хүний тухай мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглох, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хувийн болон гэр бүлийн нууц, захидал харилцаа, мэдээллийн нууц, нэр төрөө хамгаалах эрх, эрх чөлөөнд халдахыг хориглосон эрх зүйн зохицуулалтыг сайжруулж мөрдүүлнэ.

4.5 Батлан хамгаалах бодлого

Бодит байдал

Зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх, ажилтан, албан хаагчдын цалин, хангамжийг тогтмол нэмэгдүүлсээр ирсэн бодлого алдагдлаа. МАН цэрэг, цагдаа, онцгой байдал, батлан хамгаалах салбарын ажилчдын цалинг тогтмол нэмэгдүүлсээр ирсэн. 2012 оноос хошиг цэрэг, цагдаа, онцгой байдлын албан хаагчдын цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг цалинг нэмэгдүүлээгүй. Харин ч МАНын бүлгийн гишүүдийн санаачилгаар цалингийн санг 10 хувиар хасуулахгүй байхаар төсвийг батлуулсан.

Бид ингэж шийднэ



- 4.5.1 Зэвсэгт хүчний байгуулалтыг мэргэжлийн бүрэлдэхүүнд суурилсан бүтцийг нь бэхжүүлэх, олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадвар боломж нэмэгдүүлэх чиглэлээр хөгжүүлнэ.
- 4.5.2 Цэргийн албан хаагчдын эрх зүй, нийгмийн баталгааг сайжруулж, аливаа нөхцөлд үүргээ биелүүлэх боломжоор хангах тогтолцоог төлөвшүүлнэ.
- 4.5.3 Цэргийн алба нь иргэний төлөвшил, эх оронч үзэл, хүмүүжлийн жинхэнэ сургууль байх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх нь цэргийн байгуулалтыг хөгжүүлэх бодлогын нэг үндсэн чиглэл байна.
- 4.5.4 Хилийн цэргийн зохион байгуулалтын өнөөгийн тогтолцоог хэвээр хадгалж, хил хамгаалах бодлогыг шинэчлэн төгөлдөржүүлэх, хилийн боомтуудыг холбосон өргөн зурvasын сүлжээнд суурилсан цогц, удирдлага хяналтын систем бий болгоно.
- 4.5.5 Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэнэ.

4.6 Гадаад бодлого

Бодит байдал

Дэлхийн улс орнуудтай харилцах төрийн гадаад бодлогын залгамж чанар алдагдаж, алдаатай бодлого хэрэгжүүлсэний улмаас Монголын төрд итгэх итгэл сэвтэж, эдийн засгийн хамтын ажиллагаа зогсоног байдалд орж, гадаадын хөрөнгө оруулалт огцом уналаа. МАН засаг барьж байх 2012 онд дэлхийн том хэвлэлүүд Монголыг "хоёр дахь Кувэйт" болно гэж бичдэг байлаа. Харин 2015 онд "хоёр дахь Грек" болно гэж зөгнөн зарлаж байна. Монгол Улсын зээлжих зэрэглэл өнгөрсөн 4 жилийн хугацаанд 4 дахин уналаа.

Дэлхийн санхүүгийн гол хэвлэл болох "Financial times" сонинд Монгол Улсыг ДНБ-д эзлэх дотоод өрийн хэмжээгээрээ дэлхийд 2 дугаарт буюу Исландын дараа дорроо орохоор болсон гэж зарлав. "The Economist" сэтгүүлд Монгол Улсыг ДНБ-д эзлэх гадаад өрийн хэмжээгээрээ дэлхийд 2 дугаарт буюу Зимбабве улсын дараа оруулж дэлхий дахинд ойлгуулав. Дэлхийн банк, Олон Улсын Вальютын сан зэрэг санхүүгийн томоохон байгууллагууд "Монголын эдийн засагт зохицтой бодлого хэрэгтэй болсон, эрсдэлүүд нэмэгдэж байгаа"-г байнга сануулсаар ирэв. Дөрвөн жилийн дотор манай улсын гадаад нэр хүнд ингэж буурлаа.

Бид ингэж шийднэ

- 4.6.1 Монгол Улсын гадаад бодлогын нэгдмэл, залгамж чанарыг хангана.
- 4.6.2 Монгол Улсын үндэсний язгуур эрх ашиг, аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар туштай хангаж, эвсэлд үл нэгдэх, олон тулгуурт, энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан гадаад бодлогыг хэрэгжүүлнэ
- 4.6.3 Хөрш хоёр оронтой уламжлалт найрсаг, эв тэгш харилцаагаа бэхжүүлж, "туравдагч хөршийн" бодлогын хүрээнд бусад улстай хамтын ажиллагаагаа хөгжүүлнэ.
- 4.6.4 Аюулгүй байдал, хөгжил дэвшлийн баталгаа болсон үндэсний эв нэгдэл, нийгмийн зөвшлилцлийг эрхэмлэн цогцлооно



ТАВ. НИЙСЛЭЛИЙН ХӨГЖИЛ

Бодит байдал

Монгол Улсын хүн амын тал шахам хувь нь нийслэл Улаанбаатар хотдоо амьдарч байна. Хүн ам хэт төвлөрсний улмаас агаар, хөрсний бохирдол, авто замын түгжрэл, эмнэлэг, сургуулийн хэт ачаалал зэрэг олон тулгамдсан асуудал бий боллоо.

Нийслэлийн агаарын бохирдол Дэлхийн эруул мэндийн байгууллагаас гаргасан зөвшөөрөгдсөн хэмжээнээс 25 дахин их байна. Агаарын бохирдлыг бууруулах нэг үндсэн арга хэрэгсэл нь иргэдийг орон сууцжуулах бодлого хэмээн МАН үзэж, “4000 айлын орон сууц”, “40000 орон сууц”, “100000 айлын орон сууц хөтөлбөр”-үүдийг санаачлан хэрэгжүүлж байсан. Эдгээр хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхдээ ипотекийн зээлд хэт шүтэж, иргэдийн газрыг үнэгүйдүүлж, ёмч хөрөнгөд нь халдаж байна.


Мөн 4 жилийн өмнө Улаанбаатар хотын утаа, хог хаягдалтай тэмцэх цогц “Аюулгүй орчинтой монгол хүн” цогц зорилтыг дэвшүүлж, 2013, 2014 онд энэ үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн хэмжээг хэд дахин нэмэгдүүлэн ч “хогны ногоон уут тараах”, “хогийн сав хийх”, “нэг наст цэцэг” тарихаас хэтэрсэнгүй, тодорхой үр дүн ч гарсангүй.

2000-2012 онд Улаанбаатар хотын төсвийн орлого ердөө 935 тэрбум төгрөг байсан бол 2012-2016 онд 1 их наяд 878.2 тэрбум төгрөг болж огцом нэмэгджээ. Төсөө ийнхүү нэмэгдсэн ч нийслэлийн тулгамдсан асуудлууд шийдвэгдсэнгүй. Харин ч 2012 онтой харьцуулахад нийслэлийн төрийн албан хаагчдын тоо 3000 орчмоор нэмэгдэж, нийслэлийн засаг дарга хууль бусаар б орлогчтой болох зэрэээр үргүй зардал нь өсчээ.

Шийдэл:

5.1 Хот төлөвлөлт- дэд бүтэц

- 5.1.1 “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 5.1.2 “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 5.1.3 Улаанбаатар хотын бүсчлэлийн тухай хууль батлуулж, бүсчилсэн төлөвлөлт хийн хөгжүүлнэ.
- 5.1.4 Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн гэр хорооллыг хөгжүүлэх шинэ үзэл баримтлал боловсруулж, дахин төлөвлөлтийн эрх зүйн зохицуулалтыг бүрэн ханган хэрэгжүүлж, хохирсон иргэдийн эрх ашигийг хамгаалах арга хэмжээ авна.
- 5.1.5 Нийслэлийн дагуул хот, тосгоныг хөгжүүлнэ.
- 5.1.6 Газар доорх болон давхар зогсоолыг хоёр дахин нэмэгдүүлнэ.
- 5.1.7 Нийслэлийн томоохон, худалдаа үйлчилгээний төв, захуудын орчин нөхцлийг сайжруулах, нийслэлийн хөгжилтэй уялдуулах бодлого баримтална.



- 5.1.8 Улаанбаатар хот-Хөшигийн хөндий, хотын зүүнээс-баруун, урдаас-хойд чиглэлд хурдны зам барина.
- 5.1.9 "Гудамж" төслийг үргэлжүүлж, гүүрэн болон нүхэн гарцуудыг нэмэгдүүлнэ. Авто машингүй гудамж байгуулна.

5.2 Орон сууцжуулах таатай нөхцөл

- 5.2.1 Өмчилсөн газартаа дулаан цэвэр бохир усны системтэй, ажлын байртай, тохилог амины орон сууц барих төсөл хөтөлбөрийг бүхий л талаар дэмжиж, түрээсийн орон сууцыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.
- 5.2.2 Ашиглалтын шаардлага хангахгүй мянган айлын орон сууцыг дэс дараатай шинэчилнэ.
- 5.2.3 Дагуул хот, шинэ хот, дэд төвүүд болон аймгийн төвүүдэд орон сууц барихад дэмжлэг үзүүлж, нийслэлийн хэмжээнд 40.000 айлын орон сууц ашиглалтад оруулна.
- 5.2.4 Гэр хороолол дахь амины орон сууцыг /хашаа байшинг/ ипотекийн зээлэнд хамруулах нөхцлийг судлан хэрэгжүүлнэ.
- 5.2.5 Иргэд орон сууцаа өмчлөхийн зэрэгцээ орон сууцны талбай, буурь хөрс орчны газар, бичил дэд бүтэцтэй нь нэг багц болгон өмчлөх хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

5.3 Эрүүл, цэвэр, аюулгүй орчин

- 5.3.1 Хот, аймгуудын гэр хороололд хийн түлшний хангамж болон хэрэглээг нэмэгдүүлж, "Эко хот" хөтөлбөр хэрэгжүүлэх замаар агаарын бохирдлыг бууруулна.
- 5.3.2 Гэр хорооллын хэрэглэгчдийн цахилгааны хангамжийг сайжруулах зорилгоор цахилгаан түгээх сүлжээг шинэчилж, шөнийн тарифыг тэглэнэ.
- 5.3.3 Аюулгүй, найдвартай, их багтаамжтай нийтийн тээврийг хөгжүүлэн, үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээсэн 400-аас доошгүй автобус, тролейбусаар парк шинэчилнэ.
- 5.3.4 "Туул", "Сэлбэ", "Дунд гол"- оо хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлж, голын дагуу явган болон дугуйн зам тавьж, эрүүл, цэвэр амралт зугаалгын бүс байгуулна.
- 5.3.5 Дүүрэг болгонд цэцэрлэгт хүрээлэн, хиймэл нуур, усан байгууламжийг барина.
- 5.3.6 "Дугуйн зам" хөтөлбөрийн хүрээнд нийслэлд зам тээврийн хөдөлгөөнд дугуйтай оролцох боломжийг өргөжүүлж, дугуйн зам, замын тэмдэг, тэмдэглэл, дугуйн зогсоол зэрэг дэд бүтцийг сайжруулна.
- 5.3.7 "Дөрвөн уул" хөтөлбөр хэрэгжүүлж, нийслэлээ хүрээлсэн 4 ууланд явган болон дугуйн аялал хийх маршрут гаргана.
- 5.3.8 Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн ногоон байгууламжийг З дахин нэмэгдүүлнэ.



- 5.3.9 Ургамлын гаралтай харшлын өвчнийг үүсгэгч шарилж, зэрлэг ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах арга хэмжээ авна.
- 5.3.10 Улаанбаатар, Дархан хот, зарим аймгийн төвүүд, томоохон үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн технологийг шинэчилж, өргөтгөнө.
- 5.3.11 Томоохон хот, төв суурин газрын агаар, хөрс, усны бохирдол, орчны доройтлыг хязгаарлан зогсоож, дүүрэг бүрт хог хаягдлыг тээвэрлэх, ангилах, боловсруулах, худалдан авах цогц менежментийг бий болгоно.
- 5.3.12 Аймаг, дүүргүүд, алслагдсан хороодод Wifi интернетийн хүртээмжийг нэмэгдүүлж, амралт, зугаалгын бүс, сургуулийн орчин, номын санд ашиглах боломж бүрдүүлнэ.
- 5.3.13 Гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг, хаягжуулалтыг сайжруулж, томоохон гудамжуудыг камержуулна.
- 5.3.14 Гэр хорооллын айл өрхүүддээ ундны усны түгээлтийг ойртуулах үүднээс 500 м тутамд худаг байгуулна.

5.4. Үйлчилгээ нь шуурхай Улаанбаатар

- 5.4.1. Нийслэлийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.
- 5.4.2. Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэн хамгаалах, хотын байнгын оршин суугчдыг ажлын байраар хангах ажлыг зохион байгуулна.
- 5.4.3. Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгуулагуудыг мэргэжлийн удирдлагад шилжүүлэн, тэдгээрийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчилэн боловсруулж, мөрдүүлнэ.
- 5.4.4. Нийслэлийн хороо бурийг хүүхдийн цэцэрлэг, биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн талбайтай болгоно.
- 5.4.5. Нийслэлийн иргэд эмнэлэгт үзүүлэх очер дугаараа интернет, гар утас, цахим хэлбэрээр авдаг болно.
- 5.4.6. Нийслэлийн аливаа асуудлыг зөвлөлдөх ардчиллын зарчмаар шийдвэрлэж, иргэдийн оролцоог хангана.
- 5.4.7. Иргэддээ төрийн үйлчилгээг ойртуулж, дүүрэг бүрт төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулна.
- 5.4.8. Гэмт халдлага, гамшиг, эрсдлийн үед шуурхай үйлчилгээг цаг алдалгүй хүргэх ухаалаг систем нэвтрүүлнэ.



**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
МОНГОЛ АРДЫН НАМААС ДЭВШҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ
АЙМАГ, ОРОН НУТГИЙН ТАЛААР ТУСГАЙЛАН ОРОХ ЗААЛТУУД**

Архангай аймаг

1. Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, замыг гүйцээж мянганы замд холбоно. /139 км/
2. Аймгийн нэгдсэн эмнэлгийг орчин үеийн компьютер томографын болон дурангийн мэс заслын шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
3. Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ.
4. Аймгийн хүүхэд драмын театрны шинэ барилгыг гүйцээж ашиглалтанд оруулна.
5. Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнг "Хүүхдийн парктай" болгоно.
6. Өргөн хэрэглээний 8 нэрийн бараа бүтээгдэхүүнийг аймагтаа үйлдвэрлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
7. Газар тариалангийн бүс нутгийг түшиглэн малын тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
8. Цэвэрлэх байгууламжийг шинэчлэн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Баян-Өлгий аймаг

1. Өлгий хотын Нисэх буудлын хатуу хүчилттай зурvasыг өргөтгөж, хүнд даацын том онгоц хүлээж авах боломжийг бүрдүүлнэ.
2. Алтанцөгц, Цэнгэл, Алтай, Сагсай сумдад сургуулийн хүүхдийн дотуур байр барина.
3. Өлгий сумын төвд 120 ортой хүүхдийн эмнэлэгтэй болгоно.
4. Өлгий хот болон Дэлүүн, Булган, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл, Толбо зэрэг томоохон сумдад арьс шир боловсруулах үйлдвэр байгуулна.

Баянхонгор аймаг

1. Баянхонгор Говь-Алтайн чиглэлийн замын Баянхонгор Бууцагаан чиглэлийн замыг үргэлжлүүлэн барьж ашиглалтанд оруулна.
2. Баянхонгор сумын дулааны шугам сүлжээг шинэчилнэ.
3. Заг, Гурванбулаг, Хүрээмарал, Бууцагаан Жинст, Баян-Овоо сумдад соёлын төв барина.
4. Баянхонгор суманд усан бассейн бүхий спорт цогцолборыг барьж дуусгана.
5. Баянхонгор суманд орчин үеийн 300 хүний суудал бүхий кино театр барина.



6. Цементийн үйлдвэр байгуулж, баруун бүсийг хангана.
7. Ноос, ноолуур болон мал аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулна.
8. Жил бүр 20-оос боошгүй инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргаж, 50-аас багагүй газарт усны хайгуулын ажил хийнэ.

Булган аймаг


1. Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай автозамын ажлыг хийж гүйцэтгэнэ.
2. Булган аймгийн газар тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор Хутаг-Өндөр суманд 15000 тн багтаамжтай үр тария хадгалах элеваторын барилгыг барих, Аймгийн төв, Хутаг-Өндөр сумдад төмс, хүнсний ногоо хадгалах механикжсан зоорь барина.
3. Max боловсруулах дунд зэргийн хүчин чадал бүхий үйлдвэрийг Булган, Дашинчилэн сумдад байгуулна.

Говь-Алтай аймаг

1. Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугамыг 110 кв болгон өргөтгөж, цахилгаан эрчим хүчний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
2. Аймгийн төвд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дулааны станц шинээр барьж, ашиглалтанд оруулна.
3. Сургуулийн барилга, спорт заалны барилга, 960 суудал /Говь-Алтай, Есөнбулаг, Эрүүл мэндийн ШУИС-ийн харъяа Анагаах ухааны коллеж/
4. Алтай хотыг ундны цэвэр усаар хангаж байгаа өнөөгийн түвшинг бататган цаашид төгс шийдвэрлэх зорилгоор Завхан голоос аймгийн төв хүртэлх 50 км ус дамжуулах шугам хоолой шинээр татаж, дагалдах тоног төхөөрөмжийг суурилуулан, ус цэвэршүүлэх станцын хамт барих арга хэмжээг авна.

Дорнговь аймаг

1. Сайншанд-Хамарын хийдийн засмалаас салаалж, Зүүн баян хүртэл хатуу хучилттай зам тавина.
2. Сайншанд-Замын-Үүдийн засмал замаас салаалж, Бүрдэнэ Булгийн бөөрний сувилал хүртэл хатуу хучилттай зам тавина.
3. Эрдэнэ суманд дотуур байр барина /75 хүүхдийн/
4. Сайншанд суманд "Залуус хөгжлийн төв" барина
5. Сайншанд суманд цэцэрлэг барина. /300 хүүхдийн/



6. Аймгийн төвд халдвартын эмнэлэг барина.
7. Аймгийн төвд хүүхдийн эмнэлэг барина.
8. АШУУИС-ийн аймаг дахь салбар сургуулийн шинэ хичээлийн байр барина.
9. Аймгийн төвд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төв" барина.
10. Аймгийн төвд эмэгтэйчүүдийн хөгжлийн төв барина.
11. Сайншанд суманд 1000 хүний суудалтай "Спорт цогцолбор" барина.
12. Аймгийн төвд мал аж ахуйн бүтээгдэхүүн эцэслэн боловсруулах үйлдвэрийн цогцолбор барина.
13. Сайншанд сумын цэвэрлэх байгууламжид техникийн шинэчлэлт хийнэ.

Говьсүмбэр аймаг

1. Сүмбэр, Шивээговь суманд шинэ цэцэрлэг барина.
2. Сүмбэр сумын 2-р сургууль, Шивээговь сумын 3-р сургуулийг хичээлийн шинэ байртай болгоно.
3. Аймгийн нэгдсэн эмнэлгийн 2 дахь шатлалын шинэ барилга барина.
4. Боржигон чуулгыг шинэ байртай болгоно.

Дорнод аймаг

1. Чойбалсан хотоос Хавирга, Баянхошуу, Эрээнцав хилийн боомт чиглэлд хатуу хучилттай автозам барина.
2. "Дорнод бусийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
3. Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилга шинээр барина.
4. Аймагт Хүүхдийн ордон, Спортын ордон шинээр барина.

Дундговь аймаг

- 1.Luus, Адаацаг, сумдад сургачдын дотуур байр барина.
- 2.Дэлгэрхангай, Адаацаг, Сайхан-овоо, Luus, Говь-Угтаал сумдад спорт заал барина.
3. Говийн ирээдүйн цогцолбор сургуульд спорт заал барина.
4. Эрдэнэдалай, Дэлгэрхангай суманд хүн эмнэлгийн барилга барина.
5. Төв Халхын Дуулалт жүжгийн театрын барилгын ажлыг дуусгана.
6. Адаацаг, Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил, Дэлгэрцогт сумдад соёлын төвийн барилга барина.
7. Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, хүчин чадлыг нь нэмэгдүүлнэ.

Завхан аймаг

1. Завхан аймгийн Улиастай хот, Говь-Алтай аймгийн чиглэлд орших Ширээгийн голд 120 м-ийн урттай төмөр бетонон гуурийг барина.



2. Архангайн Өлзийт-Тосонцэнгэл чиглэлийн 100 км
3. Улиастай хотын 35МВт-ын нэгдсэн Дулааны станцыг барьж, агаарын бохирдлыг бууруулан, хэрэглээний халуун усаар хангана.
4. Аймагтаа хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжинэ.
5. Улиастай хотын цэвэрлэх байгууламжийг шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Өвөрхангай аймаг

1. Хархорин – Хужирт – Арвайхээр чиглэлийн 40 км авто замыг шинээр барих зураг төсөл боловсруулж, барьж эхлэнэ.
2. Арвайхээр хотод дулааны цахилгаан станц шинээр барих асуудлыг судалж, шийдвэрлэнэ.

Өмнөговь аймаг

1. Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай автозам барих ажлыг үргэлжлүүлж дуусгана.
2. Даланзадгад-Цогтцэций чиглэлийн хатуу хучилттай автозам барих ажлыг үргэлжлүүлж дуусгана.

Сүхбаатар аймаг


1. Ноолуур, ноос угаах самнах, ээрэх зэрэг хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжинэ
2. Аймгийн төвд дулааны станц байгуулна.

Сэлэнгэ аймаг

1. Орон нутгийн чанартай нийт 200,0 км автозамыг барьж байгуулна.
2. Цахилгаан эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх, өөрийн өртгийг хямдруулах зорилгоор Сэлэнгэ аймгийн нутаг дахь "Шүрэнгийн голын" усан цахилгаан станцыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.
3. Сум бүрт төмс хүнсний ногооны зоорь барьж, ногоог жилийн туршид хадгалах, борлуулах боломжийг бүрдүүлнэ.
4. Сүхбаатар, Мандал, Сайхан суманд сүүний үйлдвэр, бусад сумдад сүү хөргөх төхөөрөмж бүхий цех байгуулна.

Төв аймаг

1. Төв аймгийн Зуунмод хотын дулааны станцыг байгуулах ажлыг эхлүүлж, гэр хорооллын айл өрхийг нэгдсэн дулаан, цэвэр бохир усны инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлнэ.



2. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь өргөжүүлэх аж ахуйн нэгж, иргэдийг дэмжинэ.

Увс аймаг

1. Увс аймгийн Улаангом суманд оношлогооний төв, хүүхдийн эмнэлэг, эхийн амрах байр барих асуудлыг судлан шийдвэрлэж, эх хүүхдийн тусlamж үйлчилгээг сайжруулна.
2. Увс аймгийн Улаангом суманд спорт, чийрэгжүүлэлтийн төв барих асуудлыг судлан шийдвэрлэнэ.
3. Малын гаралтай түүхий эд, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Ховд аймаг

1. Чоно харайхын гүүрийг ашиглалтанд оруулна. /Дөргөн сум/
2. АХБ-ны зээлийн хөрөнгөөр баруун бүсийн босоо тэнхлэгийн автозам барина. Өлгий-Ховд 100 км
3. Олон улсын нисэх буудлын барилгыг өргөтгөнө.
4. Эрдэнэбүрэнгийн Шижигтийн Усан цахилгаан станцыг барьж, ашиглалтанд оруулна.
5. Хүүхдийн 50 ортой эмнэлгийн барилга барина. /Жаргалант сүм/
6. Цементний үйлдвэр барина. /Жаргалант сүм/
7. Малын гаралтай түүхий эд болон ноос ноолуур боловсруулах үйлдвэрийг байгуулна.
8. Цэвэр, бохир усны 15 км газар доорх шугамыг шинэчилнэ. /Жаргалант сүм/
9. Малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын цэвэрлэх байгууламж барина.

Хөвсгөл аймаг

1. Мөрөн хотыг тойрсон хөдөө аж ахуй, үйлдвэр технологийн паркуудыг байгуулна.

Хэнтий аймаг

1. Даланжаргалан sumaас Бор-Өндөр чиглэлийн 45 км хатуу хучилттай зам барина.
2. 21:100 хөтөлбөрийн хүрээнд арьс шир боловсруулах, ноос ноолуур угаах үйлдвэрийг барихыг дэмжинэ.
3. Хэнтий аймгийн Чингис хотод цэвэрлэх байгууламж шинээр барих



Дархан-Уул

1. Дархан-Шарын гол чиглэлийн 48 км автозам, авто замын байгууламжийн ажлыг эхлүүлнэ.
2. Дархан хотын цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор цахилгаан дамжуулах төв шугамыг тойрог схемд шилжүүлнэ.
3. Арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрийг байгальд ээлтэй цогцолбор хэлбэрээр хөгжүүлнэ.
4. "Багш хотхон" болон "Боловсрол хотхон"-ны бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
5. Хүүхэд хөгжлийн ордонтой болно.
6. "Спорт цогцолбор"-ын төвийг бүрэн ашиглалтанд оруулах асуудлыг шийдвэрлүүлнэ.
7. Төрөх эмнэлгийг шинээр барьж, нэгдсэн эмнэлгийн хашаан доторх замуудыг өргөтгөж сайжруулна.
8. Дархан-Уул аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрүүл мэндийн хөгжлийн төв байгуулна.
9. Дархан-Уул аймагт өндөр настан тэтгэвэрт гарсан иргэдийн асран хамгаалах "Герентологи"-ийн төв байгуулна.
10. Дархан хотын төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлнэ.

Орхон аймаг

1. Сургууль, цэцэрлэгийг шаардлагатай багуудад шинээр барина.
/Цагаанчуулут, Ращаант, Булаг, Шанд, Уртын гол, Яргуйт, Даваат, Согоот/
2. Алслагдсан багуудад соёл, спортын төвүүдийг шинээр байгуулна.
3. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байртай болгож шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, ажиллах орчин нөхцлийг сайжруулна.
4. Орхон аймагт "Яаралтай түргэн тусlamж"-ийн цогц төвийг барьж ашиглалтанд оруулж, тоног төхөөрөмжөөр хангана.
5. Багуудыг бүсчилж, Ахмадын хөгжлийн төвүүдийг байгуулна.
6. Стандартын шаардлага хангасан музейн барилга барьж, үзмэрийн сан хөмрөгийг нэмэгдүүлж, хадгалалтыг сайжруулна.
7. Зоорьтой хүнсний зах байгуулж, төмс, хүнсний ногооны хангамжийг эрс сайжруулна.

